

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-5

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 6-41

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./ 6-41

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 22 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Батнайрамдал, Ч.Ундрэм.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, аудитор Ж.Мөнхбилгүүн, Г.Оюунтөгөлдөр, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, мөн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Даваажаргал, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Сэргэлэн, Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Г.Батдорж, Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ч.Энхтуяа, Төсвийн нэгтгэл, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Т.Ууганбаяр, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Соёл, урлагийн газрын дарга Н.Мөнхзул, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга Э.Энхпүрэв, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны захиргааны хэлтсийн дарга Л.Энхтунгалаг, Шинжлэх ухааны паркийн гүйцэтгэх захирал Б.Амарсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Төсвийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав нар танилцуулав.

Танилцуулга болон дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Б.Хэрлэн, Ц.Мөнхтуяа, А.Ганбаатар, Д.Бум-Очир, Б.Найдалаа, Ж.Галбадрах, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацийн шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Б.Урьболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Дамдинням: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн хавсралт 1.28.5.1-д “Хүн амд албан, албан боловсролд хамрагдаж, ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ” гэснийг “Хүн амд албан ба албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн үг хэлэв.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 14.1.3.1 заалтын зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ гэсэн дээр Боловсролын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд 3 тэрбум төгрөг бууруулах дүн, зардал нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэм хэмжээ гэсэн дээр Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 3 тэрбум төгрөг гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа үг хэлж, Боловсролын сайд П.Наранбаяр тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 12
Бүгд: 13

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн гаргасан, Төслийн 14.1.3.1 Боловсролын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд гэж зааснаас 1.5 тэрбумыг бууруулж, зардал нэмэгдүүлэх төсөл дээр Завхан аймгийн Улиастай сумын 3 дугаар цэцэрлэг, 200 хүүхдийн өргөтгөлийн барилга барих 1.5 тэрбум төгрөг гэж гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 12
Бүгд: 13

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан зардал бууруулах төсөл, арга хэмжээний нэр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны төсвийн зарцуулалт 13 дугаар хавсралтад заагдсан Боловсролын сайдын багцад санхүүжүүлэгдэхээр тусгагдсан Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн зэрэг 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төсвийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэхтэй холбоотой Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах зардлын хэмжээг Боловсролын сайдын урсгал зардлыг 16 тэрбум 492.5 сая төгрөгөөр бууруулах, зардал нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээн дээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлж, Боловсролын сайд П.Наранбаяр тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 12
Бүгд: 13

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан, 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 4.2.1.1-д заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсөл, арга хэмжээ, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын төсвөөс санхүүжих

дүн 30.4 тэрбум төгрөгийг гэснийг бууруулах, 10 тэрбум төгрөгөөр бууруулна. Зардал нэмэгдүүлэх төсөл дээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн хавсралт төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж жагсаалтын 4.2.2-т тоног төхөөрөмж, 4.2.2.1-д хэрэглээний био технологийн лабораторийн тоног төхөөрөмж гэж тусгасан, тусгасан дээр 10 тэрбум төгрөг нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 5

Бүгд: 13

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг “дэмжсэнээр” хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэхээр бичгээр гаргасан саналыг үндэслэн дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрахын гаргасан, Төслийн 14.1.1.137 зардал бууруулах төсөл, арга хэмжээ Цэцэрлэгийн барилга буулгаж шинээр барих 240 ор, Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг, бууруулах дүн 5 тэрбум 910.4 сая төгрөг, зардал нэмэгдүүлэх төсөл Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ортой, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо, 2 тэрбум 100 сая төгрөг, 2.Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ортой, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, 3 тэрбум 100.4 сая төгрөг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах үг хэлэв.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 7

Бүгд: 13

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2.6.34 зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын хүүхэд, залуучуудад соёлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрхийн бичиг төрөөс үнэгүй олгох, бууруулах дүн 18.3 тэрбум төгрөг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа үг хэлж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 9

Бүгд: 13

30.8 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 03 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 86.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим 14 цаг 22 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Дамдинням: Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан эхлэхэд бэлэн боллоо.

Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Батнайрамдал гадаад томилолттой, Бум-Очир ирсэн, Бямбасүрэн ирээгүй, Галбадрах ирсэн, Ганбаатар ирсэн, Хэн? Бямбасүрэн ирсэн байна уучлаарай. Ирцээ бүртгүүлнэ шүү. Ганбаатар ирсэн байна, Дамдинням ирсэн, Найдалаа ирсэн, Мөнхтуяа ирсэн, Рэгдэл ирсэн, Саранчулуун ирсэн, Сарнай ирсэн, Ундрам гишүүн томилолттой байгаа, Хосбаяр ирээгүй байна, Хэрлэн ирсэн, Эрдэнэбат гишүүн ирсэн.

Байнгын хорооны гишүүдийн ирц 80 хувьтай байгаа тул өнөөдрийн хуралдааныг эхлүүлъя. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал,

1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл, Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр

дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг эхлүүлъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсэг Сангийн сайд Жавхлан, Боловсролын сайд Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Номин, Монгол Улсын Ерөнхий аудитор Загджав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Золбоо, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Энхболд, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Ичинноров, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Монгол Улсын аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням, Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал Наранчимэг, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитын менежер Мөнхцаирал, Гүйцэтгэлийн-Нийцлийн

Аудитын газрын аудитын менежер Энхтуяа, Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитор Мөнхбилгүүн, Санхүү-Нийцлийн аудитын газрын аудитор Оюунтөгөлдөр, Эдийн засгийн, хөгжлийн яам, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны дарга Энхпүрэв? Энэ хүн байхгүй байна. Ирүүлээрэй. Байгаа юм уу? Аан за. Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Гэрэлбат? Босоод сууна. Эдийн засаг, хөгжлийн яамны Технологи, инновацын шилжилт, эрчимт хөгжлийн судалгааны хэлтсийн дарга Урьболд, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангийн ажлын албаны Захиргааны хэлтсийн дарга Энхтунгалаг, Боловсролын яам, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир? Ням-Очир ирээгүй юм уу?

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам,

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Даваажаргал, Соёл, урлагийн газрын дарга Мөнхзул, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга, Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэрэнболд. Энэ хүмүүс нь ирээгүй байгаа юм байна тээ?

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сэргэлэн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Залуучуудын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Батдорж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Стратеги бодлого, төлөвлөлтийн

газрын ахлах шинжээч Энхтуяа, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төсвийн нэгтгэл, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч Ууганбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг цугласан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх саналыг, танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайдад микрофон өгье.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхний өдрийн мэндийг эрье. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Ирэх 2025 он нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх гарааны бүтэн жил учраас төсвийн бодлогыг бүсчилсэн хөгжилд зайлшгүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай юм.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсөвт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарыг дэмжих

чиглэлээр тусгасан онцлог арга хэмжээг дурдъя.

1.Нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчдын тоог жил тутам тодорхой хувиар бууруулах зорилтын хүрээнд улсын хэмжээнд шинээр ашиглалтад орох 50 ЕБС-ийн нийтлэг үйлчилгээг хувийн хэвйлээр гүйцэтгүүлэхээр төлөвлөж, холбогдох зардлыг төсвийн төсөлд тусгасан.

2.Сургуулийн хүртээмж, бүлэг дүүргэлтийн зохистой түвшнийг үр ашигтай байдлаар зохион байгуулах нэг хэлбэр гэж үзэн хувийн хэвшлийн эзэмшиж байгаа шаардлага хангасан байрыг боловсролын сургалтын үйл ажиллагааны зориулалтаар түрээслэхээр төлөвлөлөө.

3.Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хүүхдийн хоолны шим тэжээл, илчлэгийг өдөрт авбал зохих хэмжээнд хүргэхийн тулд хоолны зардлын нормативыг 2025 оны төсвийн жилд нэмэгдүүлж, орцод сүүн бүтээгдэхүүн нэмэх, түүнчлэн цэцэрлэгийн хүүхдийн болон сургуулийн дотуур байрны хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг эхэд нь хариуцуулж, тэдний хяналт, оролцоог нэмэгдүүлэх замаар хоолны чанар, илчлэгийг сайжруулах зорилт тавьж байна.

4.Гадаадын жуулчдыг Монгол Улсад аялах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгаль, соёлын төвд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс бий болгох, соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан өргөжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээний зардлыг төсвийн төсөлд тус тус тусгалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 33.9 их

наяд төгрөг, суурь зардал 32 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1.9 их наяд төгрөгийн ашигтай байхаар байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Дамдинням: Жавхлан сайдад баярлалаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт бүхий аудитыг хуулийн хугацаанд хийж

гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянахад чиглэсэн.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шаардсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шат болон Нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд нь төлөвлөсөн орлого 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.6 хувь, нийт зарлага 35 их наяд 795.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 37.7 хувь, төсвийн суурь тэнцэл 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай, төсвийн тэнцвэржсэн тэнцэл 1 их наяд 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ.

Боловсролын сайд 4 их наяд 598.1 тэрбум, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 598 тэрбум, Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төсвийн төвлөрүүлэх орлогын төслийг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад Боловсролын сайдын багцын харьяа байгууллагын өрийн

орлогыг 0.32 тэрбум төгрөг бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын орлогыг 0.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Нийт зардал ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсвөөс 439.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь дараах шалтгаантай байна. Энд, үүнд:

Боловсролын сайдын урсгал зардлын төсвийг 663.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 4 их наяд 90.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн. Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 294.2 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 26 тэрбум, ...зардлыг 67.7 тэрбум, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хураамжийг 92.5 тэрбум, Засгийн газрын урсгал шилжүүлгийг 32.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 198 төсөл, арга хэмжээ, нийт 506.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс 7 төсөл, арга хэмжээнд 85.6 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлын төсвийг 101.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 432.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс болон нэмэлт урамшууллын зардлыг 31.1 тэрбум, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.9 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 6.3 тэрбум, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаасыг 33 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 53 төсөл, арга хэмжээ, нийт 165.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 3 төсөл, арга хэмжээнд 30 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23 дугаар 23.1-д заасан шалгуурыг хангасан гэж дүгнэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Дамдинням: Загджав даргад баярлалаа. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулттай гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Гишүүд кнопоо дараад тэгээд ирцээрээ орчих байх шүү. Болсон уу? Рэгдэл гишүүнээр тасалъя. Хэрлэн, Галбадрах болсон уу тээ? Галбадрах гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Баярлалаа. Энэ шинжлэх ухааны салбарын төсөвтэй холбоотой 2, 3 асуулт байна. Тэгэхээр сүүлийн жилүүдэд ер нь бас бодлогын түвшинд шинжлэх ухаан руугаа нэлээн гүнзгий хандаж, янз бүрийн баримт бичиг нэлээн гаргалаа. Монгол Ардын намын дарга Шинжлэх ухааны академитай хамтран ажиллах гэрээ байгууллаа, Шинэ сэргэлтийн бодлогын 30, 31-40 он хүртэлх үе нь бол шинжлэх ухаан, технологи, инновацад суурилна гэдгийг албан ёсоор зарлаж байна

Засгийн газраас. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт, 2024, 2028 оны хөтөлбөрт шинжлэх ухааны салбарын зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэж, мэдлэгийн эдийн засаг хөгжүүлнэ гээд заачихсан байж байгаа.

Тэгэхдээ зэрэг энэ бодлогын баримт бичгүүд ер нь хэрэгжих ёстой, жил болгон төсөв дээр энэ тусгагдаж байх ёстой юм. Эдийн засаг, хөгжлийн яамнаас энэ 25 оны төсөвт шинжлэх ухааны салбарын барилгын хөрөнгө оруулалтад 60 тэрбум, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 61 орчим тэрбум төгрөгийн санал явуулсан боловчиг энэ тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт ерөөсөө байхгүй байна.

Ер нь Монгол Ардын нам засгийн эрх барьсан сүүлийн 7 жилд тоног төхөөрөмжид хөрөнгө оруулалт хийсэнгүй. Тэгэхээр энэ салбар чинь тоног төхөөрөмжөө шинэчлэхгүй юм бол уначхаад, энэ өмнө дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлэхэд ихээхэн бэрхшээл учирна. Тэгэхдээ зэрэг энэ бодлого барьж байгаа, зарлаж байгаа бодлого маань үнэн, бодитой, цаасан дээр үлдэхгүйгээр ажил болох ёстой юм бол энэ 8 дахь жилдээ энэ тоног, төхөөрөмж дээр жаахан хөрөнгө оруулалт хиймээр байгаа юм.

Ингэхгүйгээр бид нар шинжлэх ухааны салбараас, технологийн салбараас нэг их өгөөж хараад байх ч арга байхгүй. НҮБ-ын 2001 оны зөвлөмжөөр хөгжиж байгаа орнууд ДНБ-ийхээ 1 хувийг шинжлэх ухаан, технологидоо зарж байж сая эдийн засгийн бодитой ашиг, өгөөж хүртэнэ гээд зөвлөмж болгоод бүх хөгжиж байгаа орнуудад өгчихсөн байж байдаг.

Тэгэхээр зэрэг асуулт юу байна вэ гэх дээр зэрэг яагаад ингээд энэ Засгийн газар 8 дахь жилдээ энэ ядарсан салбартаа хөрөнгө оруулалт хийхгүй гэж шийдсэн юм бэ гэдэг ийм асуулт байна.

Ер нь гол асуулт энэ дээ. Олон хүн асуух юм байна ингээд болчихъё.

Г.Дамдинням: Рэрдэл гишүүний асуултад Эдийн засаг, хөгжлийн яамныхан хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам хаана байна? Ажлын хэсгийн 3 дугаар микрофон дээр очоод суучих. Тэндээс хариулъя. Оператор ажлын хэсгийн 2-ыг өгчхөөрэй.

Б.Урьболд: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн хэлтсийн дарга Урьболд байна.

Манай Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд шинжлэх ухаантай, шинжлэх ухааны салбартай холбогдуулан, хөрөнгө оруулалттай холбогдуулан нийт 110 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байгаа. Сангийн яаман дээрээ энэ манай санал хянагдаад Улсын Их Хуралд өргөн барьсан нь энэ 31 аравны, 31 тэрбум төгрөг буюу үргэлжлэн хэрэгжиж байгаа 2 хөрөнгө оруулалтын төслийг л санхүүжүүлэхээр өргөн барьсан байгаа.

Г.Дамдинням: Өөр нэмж хариулах хүн бас байна уу?

Алга байна. Рэрдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Яагаад гэдэг асуулт л тавьж байгаа юм л даа. Яагаад ингээд гэнэтхэн бүгдийг нь хасаад хаячихдаг юм? Энэ чинь ямар нэгэн, та нарт Сангийн яамны зүгээс тайлбар өгсөн байх гэж би бодоод байгаа юм. Энэ бодлого маань төрөөс явуулж байгаа хөгжлийн бодлогын эсрэг явах гээд байгаа юм уу, эсвэл ерөөсөө энэ мега төслөөр Монгол Улс амьдарна гэж тооцоод байгаа юм уу? Энэ чинь яагаад гэдэг асуултад л хариу өгөхгүй бол хасчихсан байна лээ, үгүй байна лээ гэдэг хариулт биш шүү дээ.

Г.Дамдинням: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Шинжлэх ухааны салбарт 2019 онд 37.5 тэрбум төгрөг төсөвлөж байсан байна. 5 жилийн дараа буюу 2025 онд 100.2 тэрбум төгрөг төсөвлөсөн байна. Тэгэхээр жил бүр сүүлийн жилүүдэд буурсан гэдэгтэй би санал нийлэхгүй байна. Тодорхой хэмжээнд өсөөд явж байгаа.

Дээрээс нь сүүлийн 2 жилийн хугацаанд, сүүлийн 3 жилийн хугацаанд шүү ер нь бүтээн байгуулалтын төслүүдийг нэг бүрчлэн авч харах юм бол яг 1 төслийн тухайд хамгийн том төсөл шинжлэх ухааны салбар дээр хийгдэж байгаа. Хамгийн том төсөл шүү. Монгол Улсын төслийн түүхэнд 150 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ийм бүтээн байгуулалтын ажлыг төсөв өөр дээрээ аваад хийсэн анхны төсөл болж байгаа. Та сайн мэдэж байгаа байх тээ төслийг? Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолбор энэ 154.5 тэрбум төгрөгийн ийм төсөвт өртөг.../минут дуусав./

Г.Дамдинням: Нэмэлт 1 минут Жавхлан сайдад.

Б.Жавхлан: Тэгээд 26 онд ашиглалтад орох юм байгаа юм. Энд бол 72 мянган м2 бүхий 7 блок цогцолбор байна. Энэ маш том цогцолбор, үндэсний хэмжээний ийм том цогцолбортой ер нь өөр байгууламж ер нь байхгүй байгаа одоогоор. Энэ бол маш том сав учраас энд маш олон шинжлэх ухааны байгууллагууд мэдээж төвлөрч таараа. Энд шаардагдах харин тоног, төхөөрөмжүүдийг тухайн жилд нь буюу 26 онд ашиглалтад орохтой холбогдуулж, ингэж цаг үе, цаглаврын хувьд тэгж зохицуулах хэрэгтэй. Тэгэхгүй, тийм, тэгэх нь зөв, илүү оновчтой болов уу гэж ингэж харж байгаа.

Дээрээс нь 2025 оны тухайд бол бүх төсвийн ерөнхийлөн захирагч нар маань л шинэ шинэ барилга байгууламж, хөрөнгө оруулалт хийнэ гэж маш их хэмжээний санал ирүүлсэн, маш их хэмжээний. Нэг нь ч ороогүй. Эндээс зөвхөн эрчим хүч, зам, тээврийн нийтдээ 38 төсөл л орж байгаа. Яг энэ зарчмаар бүсчилсэн хөгжлийнхөө энэ суурь үзэл баримтлал болон тэр.../минут дуусав./

Г.Дамдинням: Болсон уу та, тодруулах уу? Нэг боломж байна. Рэгдэл гишүүнд дахиад 1 минут.

Д.Рэгдэл: Би шинжлэх ухааны салбарын лабораторийн тоног төхөөрөмж дээр л асуугаад байгаа юм. Тэр том цогцолбор бол хугацаатай, графикаараа бол ер нь их боломжийн явж байгаа шүү дээ. Тэгээд тэр чинь эхний ээлжид энэ оны эцсээр орно. Тэгээд тоног төхөөрөмж байхгүй, хоосон байшинд ашиглалтын зардал төлөөд суугаад байх юм уу? Ер нь нэг тийм ойлгомжгүй нөхцөл юм. Гол нь бол тоног төхөөрөмжид яагаад энэ 8 дахь жилдээ Монгол Ардын нам хөрөнгө оруулалт хийхгүй гээд байгаа гэдэг л асуулт байгаа юм.

Г.Дамдинням: Рэгдэл гишүүн ээ Монгол Ардын нам ч нэг их төсөв тавихгүй л байх миний бодлоор бол. Асуултынхаа хаягийг жоохон андуурч асуусан болов уу. Тэгэхээр Сангийн сайд та хариулах уу? Жавхлан сайд.

Б.Жавхлан: 2026 онд ашиглалтад орох лабораторийн хэсэг дээр нь тоног төхөөрөмжүүд, санхүүжилт нь бол тавигдсан байгаа шүү. Нийтлэг салбарын сайдын орон даяар улсын хэмжээнд эхэлсэн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын хэмжээн дотор Номин сайд танай дээр хэд байгаа билээ? Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж хэд? Нийт дүн нь хэд байгаа билээ? Тийм тэндээсээ сайд нь өөрөө аль салбарт, одоо 4 салбар хариуцаж байгаа

сайд шүү дээ. Тэгээд аль салбарт нь ямар тоног төхөөрөмжүүд, байрлалын хувьд, мапинг ямар байх нь уу Сайд өөрсдийнхөө салбарын бодлогоороо энийг хуваарилалтаа хийгээд явна. Тийм.

Г.Дамдинням: Номин сайд дэг сахиарай. Хэрлэн гишүүн. Гишүүдэд сануулахад, Хэрлэн гишүүний микрофоныг түр байж байгаарай. Гишүүдэд сануулахад Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа асуулт 3 минут, тодруулга 1, 1 минут. Нийтдээ 5 минут байгаа. Хариулт 4 минут, тодруулгад 1, 1 минут 2 удаа өгч болно гэсэн дэгтэй байгаа шүү.

Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр миний асуулт бас Рэгдэл гишүүний асуулттай ерөнхийдөө их холбоотой зүйл. Тэгэхээр 2025 оны улсын төсвийн хөрөнгөөр боловсролын салбарын 186 барилга, байгууламж 1 их засварын төсөл, арга хэмжээ, 5 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээ төсөвлөгдөж орж ирсэн байна л даа. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын 4 барилгын асуудал яригдсан. Одоо төлөвлөгдөж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр би ер нь боловсролын чанарын тухай асуудлыг ярьж байна. Яг энэ цаг үед өнөөдөр бид нар барилга байшинд хөрөнгө оруулалт хийх нь их түлхүү энэ тал дээр анхаараад байдаг. Гэтэл яг нөгөө сургалтын орчныг бүрдүүлэх тухай асуудал сургалтын хэрэглэгдэхүүн, тэр тоног төхөөрөмжийг бүрдүүлэх тухай асуудал ЕБС, мэргэжлийн боловсролын сургууль, их, дээд сургуулиудын хувьд энэ жаахан орхигдоод байгаа юм биш үү? Ёстой нөгөө саваа бэлдэхээр саалиа бэлдэнэ гэгчээр байшин, барилгаа бариад байдаг тэр дотор чинь яг тэр сурагчид, оюутан, залуучуудад боловсрол олгож байгаа тэр гол сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг бэлдэх

тал дээр энэ төсөвт нэлээн бага тусгаад байх юм. Энийг ер нь цаашидаа яах вэ гэж би асуух гээд байгаа юм. Миний асуулт бол ердөө энэ. Өө би Боловсролын сайдаас, тийм Боловсролын яамнаас хандаж асууж байна.

Г.Дамдинням: Боловсролын сайд Наранбаяр хариулъя. Боловсролын сайд Наранбаярын.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ туйлын чухал асуудал. Бид байрыг нь бэлдчихээд дотроо тоног төхөөрөмжгүй, сургалт явуулах ямар ч боломжгүй юм байвал энэ чинь тэгээд багш нь өөрөө тататунгадах юм уу, яах юм нэг ийм л юм болно шүү дээ. Ялангуяа байгалийн ухааныг хөгжүүлбэ, инженерийн ухааныг хөгжүүлбэ гээвэл энэ технологийн хичээл, байгалийн ухааны лабораториуд хэрэгтэй. Мааш бага төсөл төсөвт туссан нь үнэн. Байгалийн ухаан дээр ердөө 1 аравны энэ лабораториуд дээр үндэс, нийт улс орны хэмжээнд 2 тэрбум хүрэхгүй 1.9 байгаа. Ашиглалтад орохоор байгаа 90 сургууль, 62 цэцэрлэгтээ зориулсан сандал, ширээ, ор эд нар гээд юм нь нийлээд, энэ төсөл нь нийлээд 32 тэрбум хүрэх үү, үгүй юу ийм юм байгаа.

Гэхдээ яах вэ одоо энэ жилдээ энүүгээр нь яваад, бүхий л сургуулийн хувьд учир нь барьсны дараа тэр ширээ, сандал, самбар тийм ээ, ийм юмнууд нь хэрэг болох учраас энүүгээр энэ жилдээ хангаад, ирэх жилээс нэмэх ийм шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ дээр бас бид бас Сангийн яамтай ярилцах ёстой, санхүүгийн түрээсийн системийг оруулж ирэх, нэг дор бүгдийг нь төсвөөр шийдэх биш тийм ээ бас ийм хувийн хэвшлийг оролцуулах эд нар гээд олон ийм механизмыг бодох ёстой юм байна гэж ингэж харж байгаа.

Тэгээд жилийн жилд л арай хүрэхгүй юм тавиад л нөгөөхийг нь

ямаар дамжуулж манай Боловсролын ерөнхий газраар дамжуулж хүн гуйлгаж ингэж явсан энэ системээс ер нь салаад автоматаар ашиглалтад ормогц л тэнд нь автоматаар хуваарилагдаж байдаг ийм хангалттай ийм систем рүү л орох шаардлагатай гэж харж байгаа.

Жишээлбэл, яг бидэнтэй их ойрхон Казахстан улс гэхэд энэ жил 240 сургуулийг иж бүрэн нэг загвараар бариад тэгээд доторх тоног төхөөрөмжийг нь бүрэн хангаж байгаа шүү дээ. Хамгийн орчин үеийн, хамгийн орчин үеийн лабораториудтай.

Тэгэхээр энэ байгалийн ухааныг хөгжүүлэх, бусад яг энэ шинжлэх ухааны суурийг тавья л гээвэл туршилттай хичээлүүд ийм юмнууд хэрэгтэй учраас. Харин энэ жил бас Сангийн яам бас энд энэ талаас нь бас сонсоод яг энэ лаборатори дээр бас нэг жоохон мөнгө тавьж өгсөн байгаа. Ийм л байдалтай байгаа. Цаашидаа энийг бас анхаарах байх аа гэж бодож байна. Баярлалаа.

Г.Дамдинням: Мөнхтуяа гишүүнт.

Ц.Мөнхтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын сайдын төсвийн багцын нийт зардал гээд 4 их наяд гаруй төгрөг орж ирсэн байгаа. Энэ зардлуудтай бол ерөнхийдөө танилцсан. Задаргаа бол үнэхээрийн хангалтгүй байна гэж үзэж байна.

Жишээлбэл, цалин хөлс, нэмэгдэл, урамшил хэсэгт яг ямар цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил хэдэн төгрөгөөр 2024 онд суусан нь, 25 онд суух гэж байгаа тухай дэлгэрэнгүй задаргаа бол хэрэгтэй байна. Цалин дээр бол зүгээр цалин гээд 2.3 их наяд төгрөг тавьчихсан байна шүү дээ. Тэгээд энэ задаргаа нь надад маш хэрэгтэй байна. Тойм төдий санагдлаа.

Хоёрт нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2024 онд 4.1

тэрбум байсан бол одоо 25.4 тэрбум буюу 614 хувиар өссөн байна. Хаана, хаана, ямар хүчин чадалтай сургууль, цэцэрлэгийн барилга түрээслэх гэж байгаа юм бэ? Тэр түрээслэх гэж байгаа барилга, байшингууд нь хэр ашиглалтын шаардлага хангах юм? Ер нь бол багш нараас гомдол маш их ирж байгаа шүү дээ. Энэ түрээслэж байгаа сургууль, цэцэрлэгүүдээс бол маш их гомдол ирж байгаа.

Тэгэхээр энэ түрээслэж байгаа мөнгөнд чинь 25 тэрбум гэдэг чинь бараг 2, 3 сургууль барих мөнгө байна шүү дээ. Тэгэхээр энийг бас нэлээн зохистой хэмжээнд авч явахгүй бол ингээд цаашдаа ингээд түрээслээд байх юм уу тээ? Энэ асуудлыг бас тавимаар санагдлаа.

Гуравдугаарт нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн дэлгэрэнгүй задаргаа бас харагдахгүй байна. Өмнөх онд 137 тэрбум, 2023 онд 59 байснаа одоо энэ жил 66.9 хувиар буюу 92 тэрбум төгрөгөөр өсөөд 201 тэрбум төгрөг болчихсон байна. Энэ дээр бас дэлгэрэнгүй задаргааг харахгүй бол нөгөө л хэрэгтэй, хэрэггүй шахаа, хулгай, худал юмнууд чинь яваад байдаг тээ? Тэгэхээр би бол хардах эрхтэй хуулийнхаа хүрээнд. Энийг бас нарийвчилж бүүр задаргааг нь хармаар байна. Боловсролын яамныхан надад энэ задаргааг өгмөөр байна.

Дараа нь бараа, үйлчилгээний бусад зардал гээд 189 тэрбумаас 201 тэрбум болж, 11.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ задаргаа нь бас тодорхой биш, зүгээр л нэг тойм төдий тэрэнд тийм юм гээд тавьчихсан байна. Энэний бүүр нарийн задаргаа нь надад хэрэгтэй байна.

Дараа нь урсгал шилжүүлэг дээр 128 тэрбум нэмэгдчихсэн. Энэ тайлбарууд нь өөрсдөө яг ийм ийм зардалд ийм төгрөг гэсэн ийм нарийн задаргаа байхгүй. Зүгээр л нэг багц багц

мөнгөнүүд тавьчихсан. Тэгээд улсын мөнгөн дээр ийм хайхрамжгүй, ийм байж болдог юм уу? Бүүр нарийн задаргааг нь тайлбарлаж өгөх хэрэгтэй байна. Миний хувьд яг ийм тодорхой бус төсөв батлахад оролцмооргүй байна. Өмнө нь ингэж явсан бол үнэхээр гайхаж байна. Энэ дээр Боловсролын сайд Наранбаяр сайдаас асууж байна. Яг тодорхой хариу өгөөрэй.

Г.Дамдинням: Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

П.Наранбаяр: Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Үнэн үнэн задаргааг нь таны шаардаад байгаа бол үнэн. Ийм бүхэл бүхлээр нь тавьчихаад сайн задаргааг нь хэлж тайлбарлах үүрэг төрийн талд бидний үүрэг мөн. Ийм учраас би энэ задаргаануудыг манай Боловсролын яамны яг асуудлаа хариуцсан газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга ирчихсэн байгаа. Өнөөдөр ер нь байгаа задаргаагаа яг энэ мөчид ийм ийм гэдгийг нь сайн тайлбарлаад хэлээд өгье. Хэрвээ яг энд мөчид энийгээ бүрэн задалж чадахгүй бол танд албан бичгээр хүргүүлбэ.

Тэгэхээр бид бол бас нэг бариад байгаа бас нэг бодлого нь ер нь энэ хувьсах зардлаар дамжуулж энэ боловсролын үйлчилгээг сургууль болгонд нь тэгш хүртээмжтэй хүргэх, сургууль болгоны онцлогт таарсан ийм үйлчилгээг хүргэх ийм бодлого барьж байгаа. Тэгэхээр энэ зүйлүүд дээр эд нар бүхлээрээ, бүхлээрээ ингэж харагдаж байвал бид танд бас энэ задалж өгье.

Байр ашиглалтын тухайд яг шаардлага хангаагүй ийм байшинд, ялангуяа сургуулийн барилгуудыг ингэж түрээслэж байгаа нь үнэн. Бид бас энэ зүгээр энэ юунд хэлэхэд нэг жишээ болгож хэлэхэд энэ Баянгол дүүрэгт байгаа Эрин интернэйшнал гээд энэ бас байгууллагатай, сургуультай ийм хэлэлцээ хийж байгаа. Энэ бол яг шаардлага хангасан 2 заалтай, гаднаа

талбайтай ийм ийм хувийн сайн сургуулийг түрээслэх замаар, алсдаа худалдан авах ийм бас боломжийг хайж байгаа шүү. Ер нь ийм байдлаар түрээсэлж яваад дараа нь худалдаж авах энэ тэр түрээснийхээ зардлыг худалдан авах зардалдаа тооцуулах нь бас нэг дор төсөвт ирэх зардлыг эрс бууруулж байна гэсэн ийм бас сайн тал байгаа.

Харин бид түрээслэхдээ тухайн стандарт, шаардлагыг тавьж явах учиртай. Энэ дээр би тантай санал нэг байна. Ингээд манайхнаас задаргаануудыг нь хэлээд хэлээд явчихъя. Батцэцэг дарга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга.

Г.Дамдинням: Бичгээр л өгсөн нь дээр дээ. Батцэцэг дарга байж бай даа. Нэгдүгээрт бичгээр гишүүнд бас тайлбарла, та нар энэ хурлын дараа танилцуулна биз.

Хоёрдугаарт бас төсөв унших ч бас жоохон явдалтай ажил. Зүгээр Боловсролын сайд танай яам уг нь 10 сарын 7-нд гишүүдийг уриад дэлгэрэнгүй танилцуулга зохион байгуулсан даа. Одоо тэрийгээ та нар маань уг нь хэлмээр л байна.

Мөнхтуяа гишүүн дахиад тодруулах уу?

Ц.Мөнхтуяа: Энэ мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан гээд байгаа юм. Энэ сангийн 224 тэрбум төгрөгийн дэлгэрэнгүй задаргаа бас байхгүй байна.

Тэгэхээр энэ 143.4 тэр тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд оруулсан гээд энэ дээр тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд тэр нь бас нарийн яг юу юунд зарцуулах вэ гэдэг нь бас тодорхой биш там тун байна.

Тэгээд төрийн бус өмчийн МСҮТ-ийн суралцагчдын хувьсах зардал гээд 17 тэрбум төгрөгийг бас тавьсан байна. Өмнө нь хувийн сургууль, цэцэрлэгүүд дээр хувьсах зардал гээд тавьдаг байсан. Одоо МСҮТ дээр бас тавьдаг болчихсон байна. Тэгээд энэ нь хэнийх нь ч шахаа юм? Бас хардах эрхтэй. Хардах эрхийнхээ хүрээнд бас асууж байна.

Г.Дамдинням: Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Тэр задаргааг би танд албан бичгээр хүргүүлэе. Харин тэр төрийн бус өмчийн МСҮТ, тэр юу бол хувьсах зардлаас нь ингээд төр хуваалцаж байгаа нь үнэн. Энэ Засгийн газрын тогтоолоор гарсан ийм шийдвэртэй зүйл шүү. Ер нь өнөөдөр 44 мянган хүүхэд яг энэ мэргэжлийн боловсролд суралцаж байгаа. Үүний бас нэлээдгүй хувийг нь бас хувийн хэвшил дээр бэлдэж байгаа. Ийм учиртай.

Тэгэхээр энэ ер нь цаашид энэ яг зөвхөн бүх хүүхдийг их, дээд сургуульд элсүүлж, оруулж, тэнд нь дээд боловсрол эзэмшүүлэхдээ бас яг мэргэжлийн эрх олгодог ийм мэргэжлийн боловсролын сургалтуудыг дэмжээд явж байгаа. Энийгээ бас ирээдүйд бид энэ бас одоо энэ хэрэгжүүлж байгаа нь Германы талтай хамтраад хосмог ийм мэргэжлийн тогтолцоо руу оруулдаг, ажиллангаа суралцах, суралцангаа ажиллах ийм боломжийг бас бий болгож байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Дамдинням: А.Ганбаатар гишүүн.

А.Ганбаатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Би төсвийн ерөнхийлөн захирагч Номин сайдаас нэг тодорхой асуулт асууя гэж бодож байна.

Энэ 35.2 дээр тив дэлхийн спортын амжилтыг нэмэгдүүлнэ гээд заасан байж байгаа юм. Тэгэнгүүт л одоо байгаа түвшин тухайлбал 35.2.1.2 дээр тивийн аварга шалгаруулах

тэмцээн-57 медаль авч байгаа юм байна дунджаар, зорилт нь 32 гэж тавьсан байгаа юм. Тэгээд нэмэгдүүлнэ гэххэд 57-г 32 руу бууруулж тавьсны учир юу вэ? Нэгдүгээр асуулт нь.

Хоёрт нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бүсийн хөгжлийг түлхэж байгаа Монгол Улс бүсчилсэн хөгжлөөр хөгжих юм байна. Бүгд ойлгож байна. Том том төслүүд бүсүүдэд өгч байгуулагдах юм байна. Үүнийгээ дагаад орчин, амьдрал тэнд үүснэ. Энэ дээр яагаад спортын кластер яригдахгүй байгаа юм бэ? Энэ дээр 186 ширхэг барилга байгууламж дотор 6-хан ширхэг спортын заалт тавигдсан байна л даа.

Тухайлбал, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Хэнтий, Өвөрхангай. Энийг буруутгаагүй. Тоо нь нэгдүгээрт бага юм биш үү?

Хоёрдугаарт энэ хүний хөгжил гээд том абзац орж байгаа шүү дээ, бүлэг. Тэгээд энэ хүний хөгжил дотор чинь хүн хөгжүүлэх гол юм нь энэ спорт баймаар юм. Тэгэхээр энэ кластер энэ бүсийн хөгжил дотор спортын комплекс энэ байгууламжуудаа ерөөсөө тавиагүй, 1 ч бүсэд 1 ч цогцолбор байхгүй. Олон улсын тэмцээнээ больё гэхэд нэг тивийн тэмцээн авдаг байхад бусад улс орны аль ч хотод очсон ямар ч насны тэмцээнийг авчихдаг шүү дээ. Тэгэхээр энэ том бодлогод энэ спорт чинь хаана яваад байгаа юм бэ? Энэ бүсийн хөгжилтэйгөө уялдаж яваа юм уу, үгүй юү гэдэг нэгдүгээр, хоёрдугаар асуудал.

Энэ Спортыг дэмжих сан дээр 1 тэрбум төгрөг тавьсан байна. Энэ бол бага байна. Бид нар спортыг хөгжүүлэе гэвэл би нэг ганцхан Исландын жишээг хэлье. Бид нар бүгд мэднэ шүү дээ. Исланд нэгэн хэсэг бол бас муу зуришлдаа автаж байсан ийм орон. Спортын байгууламжууд заал маш олноор байгуулагдаад, багш, дасгалжуулагчийг маш олноор бэлдээд хос мэргэжилтэй

ийм тамирчид гарч ирсэн. Исландын хөл бөмбөгийн шигшээ гэхэд бүгд хос мэргэжилтэй ийм тамирчид байсан. Тэгээд Исланд хэдийгээр бага хүн амтай орон ч гэсэн спортын амжилтаар Англи мэт Их Британийнхаа орнуудыг даваад ирсэн л дээ. Монголд бол ийм боломж байгаа. Тэгэхээр энэ спортын бодлогоо яаж харж байгаа юм бэ гэж.

Өөрөөр хэлбэл, спорт бол энэ зөөлөн дипломатын бодлогын үүрэг гүйцэтгэдэг. Спорт, урлаг, шинжлэх ухаан. Тэгэхээр энэ спорт чинь зөөлөн дипломатын ажил шүү дээ. Улс төрөөсөө гадна. Тэгээд энэ маань орхигдоод байх шиг байна гэж нэг ийм асуулт байна.

Г.Дамдинням: Соёлын сайд Номин хариулъя.

Ч.Номин: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Яг тэр тодорхой үр дүнтэй медалийн тал дээр бол манай Биеийн тамир, спортын Үндэсний хорооноос хариулчих гэж бодож байна. Бодлогын түвшинд би асуултад нь хариулъя гэж бодож байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монгол Улсын хэмжээнд нийтдээ спорттой холбогдолтой 80 гаруй том бүтээн байгуулалтууд Монгол Улс даяар баригдаж бий болсон байгаа. Бидний энэ жил хөрөнгө оруулалт дээр илүү түлхүү анхаарч байгаа зүйл бол ашиглалтад орсон ганц спорт гэхгүй соёлын салбарт ч гэсэн, ашиглалтад орсон бүтээн байгуулалтуудаа тогтмол үйл ажиллагаатай болгох илүү тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт дээр анхаарч ажиллаж байгаа.

Тэгэхээр бид нар өн энэ жил 27 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж дээр тавьсан. Эдгээрийгээ бид нар илүү орон нутгийн болон улсын чанартай бүтээн байгуулалтуудын үйл ажиллагааг жигдлэх дээр анхаарч ажиллана гэж бодож байгаа.

Биеийн тамир спортын хувьд бодлогын түвшинд асуулт асууж байна. Үнэн, би санал нэг байна. Өнгөрсөн хугацаанд манай биеийн тамир, спортын салбар тэр чигээрээ нэгдсэн бодлого гэж улсын хэмжээний биеийн тамир, спортын хөгжлийн бодлого гэж тодорхойлж гаргаж ирсэн зүйлгүй явсан байна.

Бидний хувьд олон улсын байгууллагуудтай хамтраад, дахиад дотоодынхоо байгууллагуудтай хамтраад, мэргэжлийн холбоонуудтайгаа хамтраад одоо цаашид Монгол Улсын биеийн тамир, спортын хөгжлийн бодлогоо тодорхойлж гаргаж байгаа. Үүнийгээ хэрэгжүүлэхдээ бид нар мэргэжлийн холбоо, клубүүдийн зарчим дээр суурилж хийнэ. Тэгэхээр энэ бодлогоо бид бүхэн тун удахгүй та бүхэнд танилцуулна гэж харж байгаа.

Кластерын зарчмаар буюу илүү яаж цогцолборын зарчмаар хөгжих тал дээр асууж байна. Бид энэ хамгийн түрүүнд Улаанбаатарт үүсгэн байгуулагдчихсан байгаа энэ биеийн тамир, спортын Буянт-Ухаа цогцолбор гэж байдаг. Энэ цогцолбор бид нар үүсгэн байгуулсан мөртөө тодорхой үйл ажиллагаанд оруулаагүй бас удаасан байна.

Тэгэхээр бид нар хамгийн түрүүнд энэ биеийн тамирын цогцолбор байдлаар буюу спорт хаб гэдгийг, тэр дундаа мэргэжлийн спорт гэж нэрлэгддэг профессионал спорт/professional sport/, элит спорт/elite sport/ буюу үндэсний шигшээ баг, цаашилаад нийтийн биеийн тамир буюу энэ комунити спорт/community sport/-ыг яаж зэрэгцүүлэн хөгжүүлж авч явах вэ гэдгийг энэ Сингапурын үндсэн зарчим дээр суурилж хийхээр төлөвлөж байгаа.

Тэгэхээр бид нар хөрөнгө, санхүүгээ бодсон ч гэсэн бүгдийг нь нэг дор байлгаад хөрөнгө оруулалтаа илүү үр дүнтэй байлгах үүднээсээ энэ би бусок буюу энэ биеийн тамир, спорт цогцолбор дээр анхныхаа кластерыг хийж, хэрэгжүүлж, энэ дээр зөв Монгол, Монгол суурьтай, Монгол агуулгатай талаасаа оруулж ирж хийчхээд дараа нь цаашилаад бүсчилсэн хөгжсөн цогцолборуудыг бий болгоно гэж үзэж байгаа.

Тэгэхээр одоо байгаа хөрөнгө оруулалтаа эргэлтэд оруулж цогцолбор байдлаар бий болгочоод дараагийн хөрөнгө оруулалтууд руугаа илүү үр дүнтэй орно гэж харж байгаа. Ойлгомжтой байж чадсан болов уу.

Г.Дамдинням: Ганбаатар гишүүн тодруулъя.

А.Ганбаатар: Тэгээд яах вэ өмнө нь энэ тив, дэлхийн спортын аварга болсон хүмүүс насан туршидаа урамшуулал авч байгаа. Энэ бол дээхэн үед хийгдсэн ийм журам, төсөл байгаа. Үүнийг өөрчлөх, өнөөгийн нөхцөлд сайжруулах ийм бодлого байна уу? Тухайлбал, энэ Сумогийн зарчим байна шүү дээ. Байгаа ид үедээ авдаг юмаа авчихдаг.

Тухайлбал, Олимпын аварга байх юм бол тэрбум төгрөг, мөнгөн медаль авбал 500 ч гэдэг юм уу, хүрэл бол 100 ч гэдэг юм уу. 1 удаадаа тухайн үедээ, яг ид үедээ амжилт гаргаж байгаа бол ингээд авчихдаг. Одоо амжилтын спорт нь буурчихсан, дараа нь тэтгэвэрт суучихсан ч юм уу, бас бус ажил хийж байхдаа тэр мөнгө аваад байгаа нь бас төсөвт бас асуудалтай байна уу, үгүй юу? Тэн дээр та бас бодлого хийх үү гээд.

Г.Дамдинням: Номин сайд.

Ч.Номин: Баярлалаа. Ер нь яах вэ Улс улс өөр өөрийн зарчмаар явдаг. Ганбаатар гишүүний хэлж байгаа зарим

талд бол хэрвээ өндөр, дээд амжилт гаргах юм бол I удаагийн өндөр дүнтэй буюу том хэмжээний дүнтэй урамшуулал олгодог. Зарим улс бол тогтмол энэ пэншин/pension/-тэй буюу тогтмол цалинжуулаад явдаг. Энэ бол манай Монголд хэрэгжиж байгаа зарчим байгаа.

Бид ер нь юу гэж харах вэ гэхээр одоо яаж энэ элит спорт гэж нэрлээд байгаа энэ үндэсний шигшээ багаа тогтмол амжилттай байлгах вэ, юу гэдэг юм Олимп болохоос өмнөх жил бүгдээрээ бужигнаад байхгүй урт хугацаандаа яаж энэ биеийн тамирынхаа, нэн ялангуяа үндэсний шигшээ багийнхаа бодлогыг авч явах вэ гэдгээ бид нар тодорхойлох нь хамгийн чухал байгаа.

Тэгээд энэнээсээ шалтгаалаад аль зарчмаар явах нь үр дүнтэй байх нь вэ? I удаагийн өндөр, дээд дүнтэй байх нь илүү сэдэлжүүлэх нь үү, эсвэл тогтмол бид нар санхүүжилттэй байж байж тухайн хүн нь өөртөө ашигтай үүнийг авч явах нь уу гэдгийг үзэж байж бид нар хийнэ гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ бодлого явж байгаа.

Г.Дамдинням: Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хоёр асуулт асуумаар байна.

Нэгд гэж байгаа, цэцэрлэгийн зориулалттай байрыг нэмж түрээслэх гэхээр одоо нийтдээ хэд байгаа юм? 10 нэмэгдэхээр хэд болох юм? Нийтдээ бид 25 онд хэдэн цэцэрлэгийн байр түрээслэх гэж байгаа юм бэ? Гол асуудал бол хэзээ энэ цэцэрлэгийнхээ байруудыг төсөвт суулгаж барьж эхлэх юм бэ? Түрээслээд яваад байна гэдэг бол төсвийн мөнгө бас тодорхой хэмжээгээр зарагдаад байгаа хэрэг шүү дээ.

Тэгэхээр энэ бол миний ойлгож байгаагаар бас хамгийн тулгамдсан

асуудлуудын нэг байх болов уу. Эртхэн 25 оны байдаг юм уу, уул нь болсон бол өнгөрсөн жил ч байдаг юм уу төсөвтөө суулгаад энэ цэцэрлэгийнхээ барилгуудыг нэг тийш нь болгоод, шийдээд явж байсан бол бид ингэж түрээсэнд улсын төсвийг үрээд байхааргүй байсан болов уу гэж бодогдож байна. Тэгэхээр энэ хэзээнээс түрээслэхээ болих юм бэ гэдэг асуултыг асуумаар байна.

Дараагийн нэг асуулт. Боловсролын энэ төсөв дээр яах вэ мэдээж төсөв нь нэмэгдээд ирж байгаад баяртай байна. Сайшаагууштай зүйл. Тэгээд энэний задаргаан дээр боловсролын төсөв 58.7 хувь ерөнхий боловсрол, 28.4 хувь сургуулийн өмнөх гээд ингээд явж байгаа. Тэгээд хамгийн сүүлд нь 5.3 хувийг боловсролын бусад хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гээд заачихсан байгаа.

Тэгээд дээд боловсрол гэдэг үг энэ дээр нэг ч байхгүй. Дээд боловсролдоо бид нар ер нь ямар нэгэн хөрөнгө, мөнгө зарцуулдаг юм уу? Төрийн өмчит их, дээд сургуулиуд чинь хэдэн багш нарынхаа хүчээр, оюутнуудынхаа төлбөрийн хүчээр 90 оноос хойш ингээд яваад байна шүү дээ. Энэ ямар бодлого баримталдаг юм бэ? Төрөөс энэ дээд боловсрол дээрээ ямар нэгэн мөнгө төгрөг тавьж, хэзээнээс тавьж өгөх юм бэ? Миний мэдэхээр бол тавьж өгдөггүй. Би өөрөө МУИС-ийн багш хүн байна. Олон мянган багш нар энийг бас сонсож байгаа байх гэж бодож байна. Сая МУИС зүтгэж байж нэг юм дэлхийд 1500-д орж ирсэн. Энэ төр, засгийн хувь нэмэр энд байсан юм уу? Би бол бараг байгаагүй гэж боддог. Улс мөнгө өгөөгүй юм чинь. Энэ нэг хэдэн багш нар л энийг 1500-д оруулж ирж байгаа шүү дээ. Яагаад 1500-д байгаа юм? Төсөв байдаггүй учраас.

Тэгээд би энэ шинжлэх ухааны, сая Рэгдэл гишүүн бас ярьж байна шинжлэх ухаан дээр төсөв гээд лабораторийн тавигдсан төсөв байхгүй болчихож гээд хэлж байна. Дээд

боловсролын салбар бол огт төсөвгүй миний мэдэхээр хэдэн жил болж байгаа юм бол би мэдэхгүй байна. Миний мэдэхийн л лав МУИС-ийн багш байхад бид нар улсаас мөнгө авдаггүй байсан. Энэ дээд боловсрол дээрээ хэзээ төсөв тавьж өгөх юм бэ? Төрийн өмчийн хэдхэн сургууль байгаа шүү дээ. 5, 6-хан сургууль. Энэ хэдийгээ нэг өөд нь татаад явж болдоггүй юм уу? Тэгээд сургуульд нь төлбөрөө нэмье гэхээр МУИС-ийг энэ тэр бол нэмүүлдэггүй.

Г.Дамдинням: Боловсролын сайд Наранбаяр хариулъя.

П.Наранбаяр: Түрээсийн тухайд нэг ийм юм байгаад байгаа юм. Би бас зарим нэгэн тоо баримтыг дурдъя. Нийтдээ 32 сургууль, 99 цэцэрлэгийн байрыг 23.6 тэрбум төгрөгөөр түрээсэлжээ. Ноднин гэхэд түрээсэлсэн байгаа. Тэгэхээр энэ нь болохоор 17803 суудал бүхий сургууль, 11980 ортой ийм цэцэрлэг болчихож байгаа юм.

Тэгэхээр энэ төсвийн талаас нь харах юм бол энэ олон хүүхдийг хамруулж байгаа нь сайн. Гэхдээ энэ яг жишээлбэл яг ийм мөнгөөрөө 23 тэрбумаар 4 сургууль, цэцэрлэг барих л мөнгө байхгүй юу. Тэгэхээр энэ чинь нөгөө хүртээмж нь бүүр бас. Тэгэхээр богино хугацаандаа энэ түрээсээ ингээд явуулна.

Гэхдээ цаашидаа яг нэг жигд стандартаар одоо пассив хаус буюу дулааны алдагдал багатайгаар энэ хамгийн газар хөдлөлтөд тэсвэртэйгээр энэ сургуулиудынхаа нэгдсэн ийм зураг төсвийг хийгээд бариад явах юм. Энэ дунд хугацаандаа бүрэн шийдвэрлэх ийм зүйл байгаа юм. Энэ жил гэхэд 90 сургууль, 62 цэцэрлэгийг оруулснаараа нийтдээ 40610 суудал, 9540 ор ингээж нэмэгдэж байгаа.

Тэгээд дээд боловсролын тухайд бол нийтдээ энэ удаад Улсын Их Хуралд өргөн барьсан энэ төсвийн 164.1 тэрбум

төгрөг нь яг дээд боловсролын урсгал зардалд зориулж оруулж ирж байгаа.

Төрийн өмчийн их, дээд сургуулиудад олгодог тогтмол зардал бол нийтдээ 14.5 тэрбум төгрөгийг тусгачихсан ингээд байж байгаа юм. Тэгэхээр дээд боловсролын байгууллагуудад урьд нь ямар нэгэн тогтмол зардлыг олгодоггүй, өөрөөр хэлбэл, ус, цахилгаан, дулааныг ингээд өөрсдөө болгоод явдаг байсанг төрөөс дэмждэг болж эхэлсэн ноднин жилээс эхлээд. Тэгэхээр энэ дэмжлэг бол энэ жил ч гэсэн ингээд явна.

Энэ 164.1 тэрбум төгрөг нь бид үндсэн үйл ажиллагааны зардалд нь жишээлбэл, түүшиц эмнэлэгт олгодог татаас байна тийм ээ? Энэ Монгол-Японы эмнэлгийн гэх мэт ингээд явж байгаа. Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт тээ? Тэгээд орон нутагт хийх, багшлах дадлагын тэтгэлэг гэх мэт ийм зүйлүүд байгаа.

Харин энэ дээр нэг зүйл ярихад энэ МУИС-ийн өргөтгөлийн тэр 3 дугаар байрных нь барилгыг дуусгах ёстой. Харамсалтай нь бас энэ төсөвт сууж чадаагүй. Яасан бэ гэхээрээ магадлан үнэлгээгээр ороод тэр зардал нэлээд хэмжээнд өсчихсөн ийм байдалтай байгаа. Тэгэхээр энэ эрхэм гишүүнээс хүсэхэд бас энэ дуусах тал дээр нь бас анхаарч өгвөл сайн байна. Энэ ноднин эхэлчихсэн ингээд өнөөдөр ийм байдалтай байгаа барилга байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Бум-Очир гишүүн тодруулъя.

Д.Бум-Очир: Тэр МУИС-ийн өргөтгөлийн асуудлыг мэдэж байгаа. Сангийн сайд хариулах юм болов уу? Хэзээ тавигдах юм бол? Уул нь тэр барилгаа ашиглалтад оруулаад авчихмаар байгаа юм.

Дараагийн нэг зүйл энэ шинжлэх ухааны гэдэг төсөв дээр дээд боловсролын байгууллагуудад оногддог юм байдаг юм уу? Бүгдээрээ Шинжлэх ухааны академи руу явчихдаг юм уу? Энийг асууж байгаа гол шалтгаан бол дээд боловсролын байгууллагууд чинь шинжлэх ухааны байгууллага биш юм уу? Одоо боловсрол дотроосоо хаягдчих гээд болдоггүй. Сая бол хэллээ тэр урсгал зардлуудыг төлдөг болсон гэж өнгөрсөн жилээс. Тэр бол сайн хэрэг. Өөр төлж байгаа, барьж байгаа юм байхгүй. Шинжлэх ухаан гэдэг дотор чинь энэ төрийн өмчит их, дээд сургуулиуд, ер нь их сургуулиуд байгаа шүү дээ. Хэрвээ бид судалгааны их сургуулиудтай больё гэж байгаа бол, төрийн бодлого байгаа бол эд нар дээр шинжлэх ухааны гэдэг зардал тавьж өгөхгүй юм бол эд нар чинь судалгааны их сургуулиуд болж хөгжиж чадахгүй шүү дээ.

Г.Дамдинням: Хэн хариулах юм? Сангийн яамны Дэлгэржаргал дарга. Ажлын хэсгийн 2 дугаар микрофон.

Ж.Дэлгэржаргал: Гишүүний асуултад хариулъя. Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар.

МУИС-ийн 3 дугаар сургуулийн өргөтгөлийн хувьд бол МУИС-ийн өөрийн эх үүсвэр болон улсын төсвийн эх үүсвэр гээд хамтарсан санхүүжилтээр явж байгаа. Улсын төсвөөс бид нар 28 тэрбумаар эхлүүлсэн. Анхны төсвийн саналд бол Боловсролын яамнаас өртөг нэмэгдүүлэх санал бол ирээгүй. Өргөн барьсны дараа магадлалын ерөнхий дүгнэлтээр одоогийн өртөг нь 45 тэрбум болсон санал ирсэн. Засгийн газраас барьсан бодлогын хүрээнд бид нар 23 онд барилгын материалын үнийн өсөлт, 24 онд аудитын дүгнэлтээр нэмэлт төсөв гээд нийтдээ 1 их наяд гаруй төгрөгийг өмнөх төслүүдээ дуусахад нэмэлт санхүүжилт болгож олгосон.

25 оны хувьд ахиад улсын хэмжээнд 300 гаруй тэрбумын нэмэлт санал ирсэн учраас үүн дээр дахиж нягтлах, хөндлөнгийн хяналт хийлгэх үүний дараа энэ нэмэлт санхүүжилтүүдийг шийдэх ийм чиглэл барьсан байгаа.

Г.Дамдинням: Сангийн сайд Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Тэр статус асуугаад байгаа нь тэр их чухал шүү. ЕБС, СӨБ хоёр бол төсөвт байгууллага. Хөрөнгө оруулалтыг нь ч улсаас хийдэг, ашиглалтыг нь ч гэсэн зохих шатныхаа төсвийн байгууллага, зохих шатныхаа төсвөөсөө хийгээд явдаг юм байгаа юм.

Энэ их, дээд сургууль бол арай өөр шүү. Энэ чинь бол юу биш, төсөвт байгууллага биш. Хөрөнгө оруулалт нь, байшин, барилгыг нь улсын төсвөөс хийдэг, тэгээд ашиглалтыг нь бол сургуульд нь шилжүүлж өгөөд, тэгээд тэр төлбөрөө аваад, тэр орлого зарцуулалтаа өөрсдөө бие даасан менежментээр хийгээд явдаг юм байгаа юм.

Тэрнээс хойших тоног төхөөрөмж тийм хөрөнгө оруулалтуудыг бол улсын төсвөөс хийдэггүй. Өөрсдөө бие даагаад явах ёстой.

Харин шинжлэх ухааны байгууллага уу, боловсролын байгууллага уу гэдгийг Наранбаяр сайдад нь хариулчих уу даа. Тэр чинь ер нь ямар статустай байдаг юм бэ? Миний бодлоор бол энэ боловсролын их, дээд шатын боловсролын байгууллага л гэж юу байх. Юу нь хэрвээ шинжлэх ухааны байгууллага болоод явчих юм бол өөр, төсвийн ерөнхийлөн захирагч өөр сайд руу яваад статус нь өөр л хуваарилагдана л даа.

Г.Дамдинням: Энэ Засгийн газар анх байгуулагдаж байхад би бас Улсын Их Хурлын чуулган дээр хэлж байсан л асуудал байхгүй юу. Одоо Боловсролын яам уг нь Боловсрол, шинжлэх ухааны яам байж байгаад сая шинэ Засгийн газар байгуулагдаад, шинэ яам байгуулагдахдаа зөвхөн Ерөнхий боловсрол, цэцэрлэгийн яам шиг болчихсон байхгүй юу. Шинжлэх ухааных нь үүрэг оролцоог Эдийн засгийн хөгжлийн яам руу оруулчихсан юм. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам энэ дээр нэг хариу өгөөдхөөч. Их, дээд сургуулиудад та нар энэ шинжлэх ухааны зардлуудаасаа өгөх ёстой юу, үгүй юу? Уг нь бол миний ойлгож байгаагаар Шинжлэх ухаан, технологийн сан, жишээ тэр бусад сангуудаасаа энэ их, дээд сургуулиудын судалгаа, шинжилгээнд өгнө гэсэн зохицуулалттай л явж байх ёстой.

Эдийн засаг, хөгжлийн яам.
Ажлын хэсгийн 2. Тэндээс хариулуулаадахъя.

Б.Урьболд: Эдийн засгийн яам, Технологи, инновацын хэлтсийн дарга Урьболд байна. Асуултад хариулъя.

Шинжлэх ухаантай холбоотой санхүүжилтийг Үндэсний Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлдэг. Үүнд бол эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, хувийн хэвшил, мөн их, дээд сургуулиуд, өрсөлдөөнт болон тогтмол зарчмаар сонгон шалгаруулалтад орж төслийн санхүүжилтийг авч санхүүждэг байгаа. Тийм, урсгал зардлын хувьд бол өмнө нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад эрдэм шинжилгээний байгууллагуудын Шинжлэх ухааны академи болон их сургуулийн хүрээлэнгүүдийн урсгал зардал суугдаж санхүүждэг байсан бол шинэ Засгийн газрын бүтцээр яг одоогийн байдлаар Эдийн засгийн хөгжлийн яамны харьяанд зөвхөн Шинжлэх ухааны академийн хүрээлэнгүүдийн урсгал зардалд суугаад

явж байгаа. Тэгэхээр энийг ирэх жилээс бас их сургуулиудын хүрээлэн.

Г.Дамдинням: Судалгаа, шинжилгээтэй холбоотой зардлууд зарим хүрээлэнгүүд их, дээд сургуулиуд дээр байгаад байгаа шүү дээ. Зарим хүрээлэнгүүдтэй холбоотой зардлуудыг энэ Наранбаяр сайд тэрийг нь хэлээч. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ их, дээд сургуулийн яг харьяанд 16 хүрээлэн байгаа юм. Энэ хүрээлэнгүүдийн урсгал зардал юмнууд бүгдээрээ их, дээд сургуулийнхаа санхүүжилттэй цуг явчхаж байгаа. Бусад хүрээлэнгүүд яг академийнхаа харьяанд байсан хүрээлэнгүүд явж байгаа. Энэ дээр бас нэг ярихад Хөдөө аж их сургууль зэрэг ийм сургуулиудад байгаа, Анагаах ухааны, шинжлэх ухааны үндэсний их сургуулийн харьяанд байгаа зарим нэг хүрээлэнгүүд бол энэ академид дагая, бид их, дээд сургуулиасаа салаад явъя гэсэн ийм хүсэлт тавиад зүгээр суулгахгүй байгаа, зүгээр суулгахгүй.

Тэгэхээр энийг нэг шийдвэрлэх, Засгийн газрын түвшинд шийдвэрлэх хэрэгтэй байгаа. Тэгтэл энд нэг юм байгаа шүү. Сургалтын их сургуулиас судалгааны их сургууль, судалгааны их сургуулиас инновацын их сургууль гэсэн хөгжлийнхөө концепцоос Монгол Улс өөрөө татгалзахад хүргэж байгаа бас л тийм таагүй үзэгдэл гэж харж байгаа шүү. Ийм л бодитой нөхцөл байдал чинь ийм байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Тийм яах вэ ер нь бол байна шүү дээ их сургууль, дээд сургуулиудад их, дээд боловсролд санхүүжилт өгөхгүй байна гэдэг асуудал нэлээн яригдаж байгаад Боловсролын ерөнхий хууль хийхэд бид нар тогтмол зардлыг нь өгдөг байж нэмж өгсөн байхгүй юу. Өгсөн шүү дээ тэр асуудлыг. Энэ чинь одоо 8.6 тэрбум төгрөг сууж байгаа байх. Энэ жилийн улсын төсөв дээр гэхэд. Энэ чинь нэлээн тасарчихсан

байсан асуудал. Тийм биз дээ яамныхан? Тэрийг нь хэл л дээ та нар. Угаасаа байхгүй байсан. Шинэ хуулиар хийж өгсөн, урсгал зардал нь явж байгаа.

Тэгэхдээ шинэ хуулиар бол их, дээд сургуулиудыг корпорац буюу компани хэлбэрээр хөгжүүлэх бүх үүд хаалгыг нь нээгээд өгчихсөн. Тэр битгий хэл бонд босгоод, өөрөө бизнес бизнес хийгээд, инновац хийгээд, татвараасаа хөнгөлүүлээд, өөртөө хөрөнгө оруулалт хийгээд явах бүх үүдийг нь нээчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэхээр зүгээр ер нь бол дээд боловсролын салбарыг удирдаж байгаа хүмүүс маань өөрсдөө менежментээ зохион байгуулаад, олж ирэх тухай асуудал ярихаас илүүтэй төсөвтэй зууралдаад байх тал руугаа хандаад байх нь өөрөө буруу хандлага байгаад байгаа юм. Тэгээд, тийм учраас энэ хуулиа сайн ойлгуулах хэрэгтэй. Ялангуяа Наранбаяр сайд тэр рүү нь бас энэ их, дээд сургуулийнхантайгаа ажиллах хэрэгтэй шүү дээ тээ. Тэр рүү нь л явахгүй юу.

Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Хэдэн асуулт товчхон товчхон асуучихъя. Боловсролын сайдаас эхэлье дээ. Дотуур байрны байр нэлээн олон байна лээ. Тэгээд бид нар нөгөө Байнгын хороон дээрээ ажлын хэсэг томилоод байгаа даа нөгөө боловсон нойлтой болох гээд. Одоо энэ байрнууд маань анхнаасаа боловсон нойлтой биз дээ? Эсвэл ардаас нь хөөгөөд барих гээд явах юм биш байгаа? Нэг.

Хоёр дахь нь Соёлын сайдаас Ховд аймгийн Жаргалантад театр барих гэж байна л даа. Кино театр болон театр тус тусад нь барьж байгаа юм. Нэлээн олон тэрбумын хөрөнгөтэй барьж байгаа юм. Энэ ямар учиртай юм? Тэгээд кино театрын чинь, байгаа кино театруудыг бид нар хувьчлахыг нь хувьчлаад, худалдахыг нь худалдаад,

бэлэглэхийг нь бэлэглээд дуусчихсан шүү дээ. Одоо шинээр төр ингээд кино театр бариад дахиад эхлэх гэж байгаа юм уу? Хэрвээ тийм байсан юм бол өмнөхөө хувьчилж яах гэсэн юм? Энэ кино театр барьдаг энийг би ерөөсөө бодлогын хувьд ойлгохгүй байна. Тэгээд цаашидаа яах юм? Аймаг болгон бариад, сум болгон кино театртэй болоод явах юм уу? Кино механикч ажиллуулаад явах юм уу?

Соёл урлагийн барилгыг хараад байхаар янз янз байна. Соёлын төв гэж байна, соёлын ордон гэж байна, цогцолбор гэж байна, өөр юу юу ч гэнэ үү 10, 20 мэдэхгүй. Ямар нэг стандарт юу байна? Ямрыг нь ордон? Ямрыг нь цогцолбор гэдэг юм? Тийм стандарт, тийм хэмжүүр, норм норматив байна уу?

Ингээд харсан чинь Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум 5000 хүнтэй 300 хүний суудалтай Соёлын төв барьж байгаа юм. Хажууд нь Хэнтийн Норовлинд 2900 хүнтэй 400 хүний багтаамжтай соёлын төв барьж байгаа юм. Энэ ямар тооцоо, юун дээр үндэслээд, энэ чинь цаана нь олон тэрбум төгрөг явж байгаа шүү дээ. Энэ яг ямар тооцоо юм? Яг ямар тооцоо юм? Ийм байна.

Дээр нь ер нь цаашидаа энэ соёл, урлаг хөгжүүлж байна гээд зөв. Гэхдээ барилга бариад л яваад байх юм уу? Барилга бариад, урсгал зардалдаа чирэгдээд л яваад байна шүү дээ. Тэгээд энэ зардал чинь өчигдөрхөн би хэлж байна лээ эрчим хүчний салбарт 199 тэрбумыг хөрөнгө оруулна энэ жил. Монгол Улс ирэх жил, соёлын салбарт 165 сая, тэрбум адилхан байгаа биз? Тэгээд энэ чинь энийгээ бодсон ч гэсэндээ бас энэ дээр ямар бодлого барьж байгаа юм бэ?

Бусдаар гүйцэтгүүлэх ажил хөлс гээд 65 тэрбум байна. Энэ яг юу юунд? Их бага мөнгө биш шүү дээ энэ чинь. Юу юунд зарцуулах, ямар ажлын хөлс вэ?

Жишээлбэл, Тамгагүй төр Лондонд тоглосон. Сайн ажил болсон. Энэ дээр төсвөөс үүнтэй холбоотой ямар нэгэн зардал гарсан уу? Гарсан бол яг хэдэн төгрөг, хэдэн мөнгө гарсан бэ? Энийг тодорхой хариулж өгөөч.

Тэгээд тоног төхөөрөмжид бас 27 тэрбум байна. Соёлын, спортын мэдэхгүй ээ юуных юм 27 тэрбум төгрөг. Сард 2 тэрбум, долоо хоногт, 2 долоо хоногт 1 тэрбум төгрөг Монгол Улс үрэх гэж байгаа байхгүй юу. Энэ яг ямар төхөөрөмж, юунд юм бэ? Иймэрхүү асуултууд байна.

Г.Дамдинням: *Соёлын сайд Номин хариулъя.*

Ч.Номин: *Найдалаа гишүүний асуултад хариулъя. Аягүй олон, маш олон асуулт байгаа учраас нэг нэгээр нь хариулаад явъя.*

Хамгийн түрүүнд албан ёсоор мэдэгдье. Тамгагүй төр гээд хувийн хэвшилээс хийгдэж байгаа жүжиг дээр Монгол Улсыг хэдийгээр олон улс маш сайн сурталчлан таниулж байгаа хэдий ч нэг ч төгрөг төсвийн санхүүжилтээс гараагүй болохыг албан ёсоор хэлье.

Гэхдээ Монгол Улсыг сурталчлан таниулж байгаа учраас бид нар бодлогын дэмжлэг бол үзүүлдэг. Очиж тухайн байгууллагын үйл ажиллагааг нээхэд нь юм уу, эс бол улс хоорондын асуудлууд дээр бодлогын дэмжлэг үзүүлдэг. Түүнээс биш ямар нэгэн мөнгө санхүүгийн төсөв гараагүй байгаа гэдгийг танд албан ёсоор хэлье гэж бодож байна.

65 тэрбум төгрөгийн бусдаар гүйцэтгүүлэх ажил дээр асуулт тавьж байна. Манай соёл, спорт, аялал жуулчлалын салбар нийтдээ 484 байгууллага байдаг. Ийм учраас бид нарт энэ байгууллагуудын тогтмол үйл хүрээнд энэ зардлууд орж ирсэн байдаг. Энэ дотор мөн хөтөлбөр, арга

хэмжээний санхүүжилтийн зардлууд орж ирсэн байдаг. Үүн дотор зарим байгууллага түрээстэй байдаг, аудитын шалгалт, дүгнэлт өгөх шаардлагууд байдаг, газрын төлбөрүүд гээд энэ олон зүйлүүд байдаг. Ингээд үзэхээр нэг байгууллагад 41.6 сая төгрөгийн ийм бусаар гүйцэтгүүлэх зардлууд орж ирсэн байдаг.

Соёл, спорт, аялал жуулчлалын яамны хувьд бол хөтөлбөр, арга хэмжээ өнөөдрийн байдлаар орж ирэхэд ойролцоогоор 45 тэрбум төгрөг байгаа. Би энийг та бүхэнд би, соёлын салбарыг ярихаар хүн болгон адлаад байдаг юм л даа. Одоо бид нар сайхан барилга барьж болно, сайхан хувцастай залуучууд байж болно, сайхан машин унаж болно. Гэхдээ хүний оюун санаа, ёс зүйд ажилладаг ганц салбар байдаг. Тэгээд энэ салбараа орж ирэхээр бүгд адлаад байдаг юм. Би зүгээр баримт байдлаар хэлээд өгөхөд нийт улсын төсвийн 1.7 хувь л соёлын салбарт зарцуулагдаж байгаа.

Урсгал зардлыг нь ярих юм бол бүүр энэнээс хэд дахин бага. Тэгээд энэ утгаараа бол энэ салбарт тэгж бүүр адлаад байхаар зардал бол байдаггүй.

Хөдөө орон нутагт соёлын төв, соёлын, ордон, дээрээс нь үндэсний урлагийн байгууллагууд гээд олон янз байдаг аа, үнэн. Соёлын төв гэдэг бол үндэс нэг дороос сумын иргэд соёлын арга хэмжээ авах боломжтой газрыг хэлдэг. Энд хүмүүс очиж ном товхимол уншдаг буюу номын сан байдаг. Энд хүмүүс соёлын үйл ажиллагаа авдаг буюу энд хүмүүс очиж дугуйлан секцэд ордог. Шөнийн оройн цагаар хүмүүс бүжиг танхимаар хийдэг.

Дээрээс нь өдрийн цагаар хурал, цуглаан хийдэг ийм зүйлүүд байдаг. Мөн үүнээс гадна орон нутгийн судлалын төв буюу тухайн орон нутагтай холбогдолтой соёлын өвийн хадгалалт, хамгаалалттай хамааралтай ажилладаг

ийм төвүүдийг нийлүүлээд сумд байж байгаа зүйлийг соёлын төв гэдэг.

Соёлын ордон гэдэг зүйлүүд илүү дүүргийн хамааралтай буюу илүү дахиад соёлын төвийн үйл ажиллагаанаас гадна бас тусдаа орлого олох боломжтой ийм төвүүдийг хэлдэг ийм ялгаатай зүйлүүд байдаг.

Бид Соёлын яамтай болсноор эдгээрт соёлын ордон, соёлын төвүүдийн стандартуудыг гаргаж байгаа. Энэ стандартынхаа дагуу нэгдүгээрт үйл ажиллагааны стандартыг гаргаж байгаа.

Хоёрдугаарт соёлын хүртээмжийнхээ стандартуудыг гаргаж байгаа. Таны асуусан кино театр яагаад Ховдод баригдаж байгаа вэ гэдэг асуулт ярьж байна.

Соёлын төвийн асуудал бол түрүүн хэлсэнчлэн илүүтэй иргэдэд номын сан, дээрээс нь орон нутгийн судлалын төв, ингээд мөн урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулах хүрээнд байдаг бол кино театр гэдэг бол энэ Ховд аймагт баруун бүсийн тулгуур төв болж байгаа гэдгээрээ энд байгаа хүмүүст зориулсан ийм кино, үйлчилгээ үзүүлэх зориулалттай газар байгаа.

Бид бүхэн Нийслэлд амьдарч байгаа учраас бид нарын соёлын хүртээмж авах боломжтой орон зайнууд маш их байдаг. С

оёлын орон зайнууд. Нийслэлийн Улаанбаатарын хэмжээнд 60 гаруй кино театрууд байдаг. Хэдий тийм боловч хөдөө орон нутагт мөн ялгаагүй хүн амьдардаг, тэр хүмүүс ч гэсэн шинээр гарч ирсэн кино урлагтай танилцах, соёлын олон төрлийг хүртэх эрхтэй байдаг. Энийг Үндсэн хуулиараа заасан. Тэгэхээр бид нар хөдөө байгаа учраас та нар кино үзэж болохгүй гэж.../минут дуусав./

Г.Дамдинням: Найдалаа гишүүн тодруулъя.

Б.Найдалаа: Би төсөвтэй холбоотой асуулт асуусан Номин сайд аа. Би соёл, урлаг ямар хэрэгтэй талаар юм сонсох гээгүй. Тэрийг би мэдэж байгаа. Дээр нь маш их дэмждэг. Энэ гишүүд бүгдээрээ мэдэж байгаа. Төсөвтэй холбоотой асууж байна. Тэгэхээр та асуултдаа л хариулбал их сайн байна. Соёл, урлаг яах хэрэгтэй, суманд соёлын төв яах, ямар хэрэгтэй талаар би бараг илүү мэдэх байх. Тэгээд тэрийг бол бүгд ойлгож байгаа юм чинь асуудал байхгүй.

Гол нь төсөв хаанаа, яаж, бодлого нь зөв явж байна уу? Буруу явж байна уу? 1970-аад оныхоор явах юм уу, эсвэл арай орчин үеийн төр, хувь хамтарсан иймэрхүү байдалтай соёл, урлагаа хөгжүүлээд явах юм уу? Эсвэл төр дээрээ тээсээр байгаад бүр хүндрүүлэх юм уу гэдгийг л асуугаад байгаа байхгүй юу. Тэгээд та түрүүнийхээ юмыг тодруулаад ярих уу тээ?

Г.Дамдинням: Номин сайд аа энэ юуны л тэр 2 суман дээр ижилхэн арга хэмжээний, хэмжээтэй, багтаамжтай, хүчин чадалтай барилгууд дээр өөр өөр төсөв яваад байгаа тухай гээд л яг төсөвтэй холбоотой юмнууд асуугаад байгаа. Тэрэнд нь хариулаадхаач. Номин сайд.

Ч.Номин: Би энэ ялгаатай ер нь бол юу тавигдсан байгааг шалгаж үзье. Ер нь бид нар стандарт гаргаад, хүнийхээ тоонд тааруулаад 1 хүнд ноогдох соёлын хүртээмжийнхээ тоог гаргаж байгаад төсөв тавигдаад явагддаг. Дунджаар сумд соёлын төвүүд 300-400 суудалтай соёлын төвүүдийг тавигддаг гэж харж байгаа. Найдалаа гишүүн би ч гэсэн төсвийн хүрээнд л танд хариуллаа л даа. Нийт төсвийн хэдэн хувь нь соёлын салбарт зарцуулагдаж байгаа, яагаад Ховд аймаг

буюу Баруун бүсийн төв дээр кино театр тавигдаж байгаа гэдгийг би танд хариулж байгаа.

Яагаад вэ гэхээр иргэд зарцуулж байгаа төсөв соёлын олон төрлийг тэр хүмүүст хүртээх ёстой учраас бид нар соёлын олон төрлийн байгууламжуудыг төсвийн хүрээнд тавигдаж байгаа юм аа гэдэг талаас нь хариулт өгсөн юм.

Г.Дамдинням: 1 минут Найдалаа гишүүн.

Б.Найдалаа: Тэгвэл тодруулаад асуугаадахъя нөгөө асуултаа. Тодруулах гээд. Стандарт ийм байшин, ийм газар, ийм юм барина гэсэн стандарт байдаг юм шиг байна тээ? Байгаа юу, байхгүй юу? Нэгд. Ямар журам, ямар шийдвэр гарсан байдаг юм?

Хоёр дахь нь түрүүн тодорхой ярьсан тэр стандартаар бодсон чинь тэгээд 3000 хүнтэй сум дээр 400 хүнтэй, 5000 хүнтэй дээр 300 хүнтэй соёлын төвийн хэмжээ гарч байна уу? Тэгээд энийг жсоохон тодруулаад өгөөч. Энэ яагаад асууж байна гэхээр энэ чинь өөрөө ийм стандарттай энэ барилга хөрөнгө оруулна гэж байгаа чинь стандарттай байхгүй бол нэг мэдэхэд бид нар бүгдээрээ энэ стандартгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт хийгээд эргээд тэрнийхээ урсгал зардалдаа живэх байхгүй юу. Төсөв дийлэхгүй. Оруулахаас өөр аргагүй болчихно. Энэ дээр хариулж өгөөч.

Г.Дамдинням: Номин сайд хариулъя.

Ч.Номин: Найдалаа гишүүндээ энэ дээр санал нэг байна. Стандарт байдаг аа. Бид нар стандартаа болохоор Стандарт, хэмжил зүйн төвөөр өнгөрсөн 2023 онд батлуулсан байгаа. Мөн Соёлын сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар соёлын төвүүдийн стандарт буюу нэг соёлын төвд хэдэн хүнтэй байхаас шалтгаалан

ямар хэмжээ, тоотой хүмүүс ажиллах вэ, ямар хэмжээний суудалтай байх вэ гэдэг дүн бол гарсан байгаа. Би дахиад тодруулж энэ мэдээллийг илүү танд илүү дэлгэрэнгүй мэдэж өгөөд бас хариулъя.

Ер нь бол бид нар дунджаар 300-400 хүний суудалтай соёлын төвүүдийг хүнээс нь хамаараад тухайн сумууд дээр байриуулдаг байгаа. Яг энэ удаа дээр ийм зөрүүтэй тоотой гарсан байна. Би энийг танд тодруулаад эргээд хэлье.

Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Та бүхэнд.../үг тасрав./

Г.Дамдинням: Юу яая сая юу яасан байна шүү уучлаарай. Наранбаяр сайд тэр дотуур байртай холбоотой асуулт дээр нь хариулчих.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээрээ 25 онд нийт 22 дотуур байрыг 43 тэрбум төгрөгөөр барина. Бүгд дотроо ариун цэврийн боловсон ийм, боловсон ариун цэврийн өрөөтэй. 20 онд, 2020 оноос эхлээд ийм шаардлага тавигдаад ер нь Монгол Улсын хаана ч барьсан хаана байснаас үл хамаараад ийм ариун цэврийн боловсон, ийм орчин үеийн ийм тоноглолтой ариун цэврийн өрөөтэй байх ийм шаардлага тавьдаг болсон байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Галбадрах гишүүн асууя.

Ж.Галбадрах: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Төсөвтэйгөө танилцсан. Мааш их асуулт байгаа. Тэгэхдээ 3-хан минутдаа багтаахын тулд ялт ч үгүй л боловсрол, тэр дотроо ерөнхий боловсрол, цэцэрлэг рүү болчихоод байна.

Миний хувьд нэг зүйлийг л давтаад яриад байгаа ер нь бол. Эдийн засаг өсөөд, төсөв тэлээд ийм боломжтой нөхцөл бүрдэж байгаа бол

бид нар боловсролдоо, хүндээ чиглүүлсэн ийм мега төсөл хийх ёстой. Энэ маань бид нарын яриад байгаа 14 төсөл дээр нэмэгдээд 15 дахь төсөл болох ёстой гэдгийг л хэлээд байгаа. Тэгээд боловсрол маань угаасаа тэргүүлэх салбар шүү. Тэгээд тэргүүлэх салбар юм бол хөрөнгө оруулалт нь хамгийн их байх ёстой. Энэ талаар бас нэлээн нарийн судалгаанууд хийсэн. Улсын хөгжил хүний хөгжлөөс, хүний хөгжил чанартай боловсролоос гэдэг.

Тэгэхээр өнөөдөр боловсролын салбарт чанар ярих нөхцөл бол ерөөсөө бүрдээгүй байгаа шүү. Би хэдэн тоогоор баталъя. 45, 40 давсан бүлэг дүүргэлтэд ийм бүлэг бол нийт улсын хэмжээнд 4860 байна. Энд нь 214 мянган хүүхэд сурч байна. Энэ чанар ярихгүй 40 давчихсан. Бүүр 60 давсан бүлэг 8 байгаа. 2000 давсан хүүхэдтэй 3000, 4000, 5000, 6000 давсан хүүхэд, 6000 хүүхэд нэг сургуульд байгаа. Ийм 2 сургууль байна. Ингээд нийт 200-аас дээш буюу 1800-аас дээш хүүхэдтэй сургууль бол 124 байна. Орон нутагт ч байна. Энд 368 хүүхэд сурч байна.

Тэгэхээр ийм байдалд хөл, толгойгоо олохгүй болсон. Энд бол чанар ярихгүй шүү. Нөгөө улсаа хөгжил гэдэг юм алдагдана. Энд багш, суралцагчийн эрх маш ноцтой зөрчигдөж байгаа. Ийм байхад бид нар ийм төсвийн хуулийг баталсаар байх уу? Тэгээд одоо миний тооцохоор Ерөнхий боловсролын сургуулийн энэ нөхцөлийг хэвийн болгохын тулд шинээр хэдэн сургууль барих вэ гэдгийг асуумаар байна. Бид нарын тооцоогоор 150 сургууль барина. Цоо шинээр шүү. Үргэлжилж байгаа юм биш ийм байгаа.

Боловсролд өнгөрсөн жил 700 тэрбум байсныг 500 тэрбум болгож багасгасан байна. Манай Сангийн сайд ташаа ойлголттой яваад байх шиг байгаа юм. Би чуулган дээр асуухад хариултаас нь хэлж байна. Өнгөрсөн 4 жилд бид нар 600 сургууль барьсан, энэ

жилд 90 сургууль, 37 сургууль Нийслэлд барина. Энэ бол хангалттай байх гэж яриад байгаа.

Тэгтэл өнөөдөр хангалттай болсон юм бол энэ дээрх саяын хэлсэн ийм нөхцөлүүд байх уу гэдгийг бас асууж байна. Тэгэхээр энийг буцаагаад ядаж өнгөрсөн жилийн төсөвт 200 болгож болохгүй юу? Энэ талаар би нөгөө зарчмын зөрүүтэй санал бэлдээд 200 тэрбумд нь хүргэх гээд 10 юм түүж үзсэн л дээ уг нь. НҮБ-ын байгууламж 50 тэрбум ч гэдэг юм уу ингээд миний асуудал ер нь цаг маань бага болчихлоо.

Дараагийн нэг асуудал бол Дэлхийн банкнаас 3 их наяд хэрэгтэй гэсэн ийм тоо байгаа. Жил бүр 20000 хүүхэд нэмэгдэж байгаа. Тэгвэл энэ шинээр төсөл гарахгүй гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байна. Багшийн дутагдал 4200-г бид нар 7000 гэсэн тоо гаргасан байгаа.

Г.Дамдинням: Дараа нь тодруулах юм уу? Авчих уу? Галбадрах гишүүн 1 минут.

Ж.Галбадрах: Уучлаарай сая. Тэгэхээр жил бүр 20000 хүүхдээр сургууль нэмэгдэнэ гэсэн тооцоо байгаа. 2038 он хүртэл л явах юм шүү. 2027 онд хүүхэд, төрөлт багасна, тэрнээс болоод багасна гэж буруу ойлгоод байх шиг байгаа юм.

Сүүлийн асуулт нь бол боловсролын, 4200 багш дутагдана гэснийг бид нар одоо тооцоод үзэхээр яг одоо байгаа бүлэг, орох цагаар нь тооцоод үзэхээр 7000 гэсэн тоо гарч ирсэн шүү. Энийг бол бүр нарийн гаргасан. Яагаад гэвэл физикийн цаг хэдэн цагт орох ёстой юм гэдгээр нь бүлгийн тоогоор нь үржүүлсэн.

Тэгэхээр манай сургуулиуд дээр энэ хөтөлбөр, энэ сургалтын төлөвлөгөөг зөрчөөд багш байхгүйнхээ улмаас зөвхөн дээшээ хүсэлт гаргаж

байгаа нь 4200 байсан байна. Тэгэхээр 7000 дутна.

Тэгээд сая 150 сургууль шинээр, бүүр цоо шинээр барих сургуулийн тоо гаргасан. Тэгэхээр энд багшийн хомсдол улам л нэмэгдэнэ. Тэгэхээр бид нар багшийн хомсдолоо арилгахын тулд хэдэн төгрөг төсөвлөсөн бэ, чанарыг нь дээшлүүлэхэд санхүүжилт бий юү гэдэг асуултуудыг асууя.

Г.Дамдинням: Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Энэ чухал асуудал хөндөж байна. Үнэхээрийн өнөөдөр энэ 1800-аас дээш хүүхэдтэй сургуулийн тоог харахаар орон нутагт 39, тэгээд Нийслэлд дангаараа 87 сургууль байж байгаа. Хүүхдийн тоо 1800-аас даваад явчихвал ер нь бол хэцүү шүү дээ. Захирал хүн уг нь хүүхдүүдийнхээ нэрийг ч хүртэл, зүсийг нь хүртэл сайн мэдэж л байдаг л байх. 1000-аас, 1800-аас дээш гараад явбал ямар ч яг хүрсэн үйлчилгээ хийж чадахгүй.

Тэгээд тэнд, энэ бол яг ингээж 1800-аас дээш хүүхэдтэй сургуулиудыг ер нь дунд хугацаандаа задлаад ер нь тийшээгээ багшийн, мөн менежерийн, захирлын энэ үйлчилгээг илүү сайн оруулах ёстой юм. Эмчийн ч гэдэг юм уу. Өнөөдөр манай Баянзүрх дүүрэгт гэхэд л 20 сургууль байна шүү дээ яг 1800-аас дээш хүүхэдтэй. Тэрний дараа нь Сонгинохайрхан, тэгээд Хан-Уул гээд явна.

Тэгэхээр энэ асуудлыг бас бид бас энэ, ирэх энэ удаагийн төсөв бол нөгөө 14 том мега төсөл, төсөвтөө баригдаж байгаа нэгд.

Хоёрт энэ эдийн засгийг чинь тэлье гэвэл энэ эрчим хүч хамгийн хэрэгтэй. Эрчим хүчнийхээ асуудлыг шийдэж байж энэ олон сургууль, цэцэрлэгээ бас барих ёстой гэсэн юм яригдаад байгаа юм. Тэгэхээр энэ

удаагийн төсөв дээр ерөөсөө Монгол Улсын Засгийн газар 38 шинэ ийм төсөв л тавьсан. Төсөл, арга хэмжээ. Энэ он дамжсан нь 152 сургууль, цэцэрлэг байгаа. Он дамжсанаар.

Тэгэхээр энэ жилийн хувьд бол бид хэдийгээр ийм байгаа ч гэсэн 26 оны төсөв дээр энийг нэлээн түлхүү тавьж өгөх байх гэж би найдаж байгаа. Ингэхгүй бол яг 2038 он хүртэл энэ 20000-ын чинь зөрүүтэй хүүхдүүд 2038 онд төгссөнө. Тэгэхээр яг энэ сургуулийнхаа яг энэ боловсрол дотроо бол ийм нөхцөл байдалтай байгаа. 27 оноос эхлээд яг элсэж орж, нэгдүгээр ангид элсэж орж байгаа хүүхдийн тоо жоохон буурах хандлагатай болсон байгаа.

1-2 дугаар ангийн 44-өөс дээш бүлэг дүүргэлттэй ийм газарт нь бид нийтдээ 2.5 тэрбум төгрөгийг төсөвлөөд багшийн туслахыг оруулж ирж байгаа юм. Багшийн туслах 1, 2 дугаар анги дээр. Энэ чинь Багшийн хөгжлийн тухай хуулийн 8.1 дээр байдаг заалт. Энэ заалтыг бид хэрэгжүүлж эхэлж байгаа л гэсэн үг.

Тэгэхгүй 44-өөс дээш дүүргэлттэй хүүхэдтэй 1, 2 дугаар ангийн хүнтэй ажиллаж байгаа багш хүн бол хүүхэд болгондоо хүрч чадахгүй шүү дээ. Багшийн туслах зайлшгүй шаардлагатай.

Багшийн хомсдолыг бууруулах чиглэлээр Засгийн газраас 6 багц арга хэмжээг зарлачхаад явж байгаа. Энэ бол багшийн мэргэжлээр төгссөн боловч багшийн ажил эрхлэхгүй байгаа хүний нөөцийг ашиглах, тэтгэвэрт гарсан багшийг бага цагаар багшлуулах, шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургууль амжилттай төгссөн энэ 80-аас дээш хувийн үнэлгээтэй 3, 4 дүгээр ангид суралцаж байгаа оюутнуудыг бас багшийн ажилд татан оролцуулах, сургалтын цагийн норм 19 цагтаа хүрээгүй, норм нь 19 цаг байдаг. Эндээ

хүрээгүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах, багш бэлтгэх их, дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар ажиллуулах, цахим сургалтыг багшийн дутагдал өндөр байдаг хичээл сургалтад илүү эрчимтэй хэрэгжүүлэх гэсэн ийм бодлогыг бид зарлаад хэрэгжүүлээд явж байгаа.

Ер нь энэ боловсролынхоо салбарт ер нь 26 оны төсөв бол энэ боловсролын салбарын өнөөгийн энэ дутагдлыг арилгахыг чиглэсэн ийм төсөл болж, төсөв болж чадна гэж би найдаж байгаа. Энэ 25 оны төсөв бол эрчим хүчнийхээ, дэд бүтцийнхээ асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ийм төсвүүд орж ирж байгаа гэдгийг та бүхэн бас ойлгож байгаа байх аа гэж найдаж байна. Баярлалаа.

Г.Дамдинням: Сангийн сайд Жавхлан нэмж тодруулъя.

Галбадрах гишүүний асуултад нэмж хариулъя.

Б.Жавхлан: Галаа гишүүнээ тэр 600 гаруй сургууль, цэцэрлэг гэдэг маань сүүлийн 10 жил шүү. Тийм сүүлийн 10 жилийн хугацаанд нийт баригдсан ийм бүтээн байгуулалтын ажлууд гэсэн үг.

Ирэх жилийн хөрөнгө оруулалтын бодлогын хувьд шинэ бүтээн байгуулалтын ажлууд ер нь байхгүй байгаа нь ганц яах вэ 38-даа ч бас биш. Тэр эрчим хүч, зам тээвэр гэхээсээ гээд 38 төсөл байгаа л даа.

Тэгэхдээ ер нь одоо манай энэ төсвийн өөрийнх нь даац болсон хүчин, дээрээс нь хамгийн гол бас нэг зүйл бол манай энэ үндэсний компаниудын энэ төсвийн хөрөнгө оруулалтад бас хүрэлцээтэй байна уу, үгүй юү гэдэг чинь аягүй хязгаарлагдмал ийм хүчин зүйл болчихоод байгаа юм. Одоо явж байгаа төслүүдээ бушуухан дуусгаж аваад, 26 оноос дахиад шинэ хөрөнгө

оруулалтуудаа эрэмбэлээд энэ шаардлагадаа нийцүүлээд эхлүүлэх нь энэ удаагийн нэг том тийм тохиргоо хийж байна гэж ойлгох хэрэгтэй.

Г.Дамдинням: Сангийн сайдад 1 минут.

Б.Жавхлан: Бид нар 23 онд бас 1 удаа ийм арга хэмжээ авч байсан юм. Тэгсний үр дүнд 24 оны бүтээн байгуулалтууд хийж байгаа. Ингээд шинэ 4 жилийнхээ эхэн дээр, гараан дээр бас нэг ийм тохиргоо жоохон амсхийгээд авбал дараа, дараа жилийн, үлдсэн 3 жилдээ бусад нийгмийн салбарууд дээрээ бас бүтээн байгуулалтуудыг үргэлжлүүлэх ийм боломж, орон зай гарч ирнэ гэсэн үг. Тэгээд энийг бас их сайн олон талаас нь ингэж харах хэрэгтэй байдаг юм тийм.

Г.Дамдинням: Танд 1 минут байгаа. Тодруулчих та, Галбадрах гишүүн.

Ж.Галбадрах: Би гол нь энд хүүхдийн эрх зөрчигдөөд байна, 40-өөрөө сууж байна, 50-аараа сууж байна, 60-аараа сууж байна. Тэгээд 1800 гарчихсан сургуульд чинь зааланд хэчнээн хүүхэд орж байгаа нь маш ноцтой зөрчигдөөд байгаа юмыг бид нар батлаад байх уу? Энд яагаад боловсролын салбар тэргүүлэх салбар гэдэг үү? Бид нар хүнээ л хөгжүүлье гэж ингэж энэ засаг хамтарсан гэж ойлгоод байгаа шүү дээ. Энэ хүний хөгжлийнхөө юман дээр яагаад энэ өмнө нь 700 тэрбум байсныг яагаад 500 болгоод багасгаад байгаа юм? Энэ жил 200-г нэмж болохгүй юу? Би уг нь ингээд зарчмын зөрүүтэй санал гээд 200 болгоод тэгвэл бас ийм юм гаргаж байгаа. Тэгэхдээ энийг манай засаг хүнээ бодоод хүнээ, хүүхдүүдийнхээ ирээдүйг бодоод, эрхээ бодоод гаргах байх гэсэн ийм асуулт гаргаад байгаа юм.

Тэгээд энэ шинэ сургууль байгуулахаар энэ багш дутагдах тал дээр би бас Наранбаяр захирлыг төсөв

төлөвлөсөн үү? Энэ тал дээр ямар төсөв байна, санхүүжилт байна гэдгийг бас асуусан. Энэ хариултаа авмаар байна.

Г.Дамдинням: Наранбаяр сайд танай сургуулийн захирал байхаа больчихсон шүү дээ Галбадрах багш аа. Тэгээд Наранбаяр сайд хариултдаа бэлдэнэ биз. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Би хөрөнгө оруулалттай хэсэг дээр нь хариулт өгье нэмж. Хөрөнгө оруулалтын зардал бол төсвийн тогтмол зардал биш, урсгал зардал болон тогтмол зардал, суурь зардал. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын зардал жил болгон өсөж байх ёстой гэдэг тийм зохицуулалт байхгүй, тийм хуулийн шаардлага ч байхгүй юм байгаа юм. Тухайн салбарын хөрөнгө оруулалтын бодлого, эрэлт, хэрэгцээ, шаардлага ямар байна вэ, тэр нь хүн амын статистик, бусад нийгмийн хэрэгцээ ямар байна вэ энэ бүх юмнаас л шалтгаалж гардаг.

Дээрээс нь энэ өөрөө бас төсвийн хөрөнгө оруулалтын энэ боломж, хязгаар, эх үүсвэрийн энэ зохицуулалт тохиргоо энэ бүх юмнаас маш олон зүйлээс шалтгаалж энэ өөрөө өсч, буурч байдаг ийм зүйл юм байгаа юм.

Тэр нарийн ширийн асуудлуудыг чиглэл, салбарын сайд хариулна биз. Тэр зүгээр миний мэдэж байгаагаар шүү би бас энэ нөгөө талаар бас энэ чинь хэрэглэгч хүн, иргэн хүн. Тэр анги танхимын дүүргэлт бол энэ сургуулийн тооноос бас шалтгаалж байгаа. Хамран сургалт энэ тэр газар зүйн байрлалаас ч хамаарч байгаа байх. Дээрээс нь энэ чанарын тухайн сургуулийн.../минут дуусав./

Г.Дамдинням: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ багшийн дутлын чиглэлээр багшийн 3 тулгуурт цогиц бодлогыг хэрэгжүүлнэ

гээд. Багшийг бэлдэх, ажиллуулж цалин хангамжийг нь сайжруулах, тэгээд тэгш хамрах сурганы арга зүй, сургуулийн менежмент гээд юмнууд орж байгаа.

Тэгэхээр бид энэ багшийн хөгжилд зориулаад 10.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Түүний зэрэгцээ түрүүнд би дурдсан 2.5 тэрбум төгрөгийг багшийн өнөөдөр 44-өөс дээш дүүргэлттэй байгаа газруудад багшийн туслах ажиллуулах энэ тал дээр бид бас төсөвлөсөн. Түүний зэрэгцээ багшийн “Эй Ай” туслах гэж ийм төслийг хэрэгжүүлэхээр 5.4 тэрбум төгрөгийг төсөвлөсөн байгаа. Энэ Монгол хэлээр явдаг энэ хичээлүүдийг ийм хиймэл оюун ухааны “Эй Ай” багшийг бас хөгжүүлэх ийм ажил явж байгаа. Тэгээд багш бэлтгэх хөтөлбөрийн олон улсын стандартын.../минут дуусав./

Г.Дамдинням: Надад бас нэг ганц, хоёр асуулт байна. Яах вэ зүгээр Боловсролын яаман дээр энэ яриад байгаа асуудлууд бол байгаа нь байгаа. Зүгээр гол асуудал бол бид нар төсөв хэлэлцээд л ажлын хэсэг хуралдаад л ингээд л явж байна. 50 гаруй хөрөнгө оруулалтын ажлуудын магадлах дүгнэлт нь өөрөөр хэлбэл, барилгын магадлах дүгнэлт нь гарчихсан байгаа юмнуудыг Сангийн яамтайгаа эртхэн ойлголцоод төсвийн хүрээндээ оруулаад, оруулж ирэх ажлаа энэ яамныхан өөрсдөө сайн хий л дээ. Тэр чинь өөрөөр хэлбэл, 50 гаруй сургууль цэцэрлэг баригдаад дуусах гээд байна л гэсэн үг шүү дээ. Тэгээд 2 ээлж нь 1 ээлж болно, 3 ээлж нь 2 ээлж болно. Тэгээд тэр ажлуудаа Сангийн яамтайгаа ойлголцоод энэ засаг дээрээ наад асуудлуудаа шийдээд оруулаад ирэхгүй энд л Их Хурлын дээр л асуудал болгоод байгаа байхгүй юу.

Түүнээс биш засгийн зүгээс бол энэ сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ улс орон даяар 3 ээлж байсныг 2 ээлж болгох ажлыг бол сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгээд яваад байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ яамнууд хоорондоо ойлголцоод хийх юмнуудаа бушуухан хийж дуусга. Тэгэхгүй тэгээд энд яваад байхаар чинь нэг утгагүй л харагдаад байна шүү.

Боловсролын сайдаас нэг асуулт байна. Тэгэхдээ энэний өмнө нэг ийм юм байна. Энэ оны төсөв орж ирсэн. Энэ оны төсөв орж ирэхэд энэ бусдаар гүйцэтгүүлэх ажил гэдэгт 1.4 их наяд төгрөг орж ирж байгаа байхгүй юу. Бусдаар гүйцэтгүүлэх ажил гэдэг зохицуулалт дээр. Тэгээд энэний зөвхөн Боловсролын сайд гэхэд 92 тэрбумаар огцом өсөөд ороод ирж байгаа юм 2025 оны төсвийн төсөл дээр. Юунд зарцуулах гэж байгаа юм? Энэ дээр нэг хариулт авчихъя.

Бусдаар гүйцэтгүүлэх ажил гэдэгт тэр гэрээт ажил, тэгээд л хэвлэл, мэдээллийн байгууллагатай хийх гэрээ гээд л юмнууд явах л байлгүй дээ. Түрээсээр авах гээд л баахан юмнууд байгаа байх. Задлаад яам яамаар нь харвал энэ их том төсөв яваад байгаа шүү урсгал дээр. Тэгэхээр энэ төсвийн ажлын хэсэг дээр бид нар яриад байгаа. Энийг хамгийн том өсөлттэй байгаа яамнуудын нэг нь бол Боловсролын яам. Энэ дээр яг ямар зардал яваад байгаа вэ гэдгээ нэгдүгээрт тайлбарлаж өгөөч.

Хоёрдугаарт, Соёлын яам. Соёлын яам энэ томилолтын зардал чинь 221 саяас 349 сая болж өссөн байна тийм үү? 57 хувийн өсөлттэй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ 57 хувийн өсөлт гэдэг бол их огцом өсөлт шүү дээ төсөв дээр. Өнгөрсөн жилийн төсөв бол гайгүй л байсан. Тэгэхээр энэ энэ яагаад өсөөд байгаа, юунд зарцуулах гэж байгаа юм та нар? Энийгээ хэлчихмээр байна.

Тэгээд энэ төсөвтэй холбоотой асуудлууд дээр ер нь сайд нар маань бас дөнгөж энэ ажлаа аваад л явж байгаа байлгүй бодвол бас. Бид нарын хувьд бас болгоод өгчих юм сан гэдэг талаас нь л хараад байгаа. Тэгээд энэ дээр, энэ

магадлалаар оруулах, өмнө нь КОВИД-ын үнийн өсөлтийг аудитаар оруулаад бас нэлээн чирэгдэлтэй тэгэхдээ бас яг магадлаад дуусгаж байсан. Энэ жил бид нар жишээ нь шаардлагыг нь яг бууруулчихсан байхгүй юу. Заавал аудитаар оруулалгүй, үнийн өсөлтийн аудитаар оруулалгүйгээр. Зүгээр л магадлалыг нь хийлгээд ир гээд. Хугацаанаас нь өмнө хийгдчихсэн баахан магадлан байгаад байдаг. Тэрийгээ төсөв дээрээ тусгаж оруулж ирэлгүй энэ чинь асуудал үүсгээд байгаа байх зарим яамнууд. Тэгэхээр энийгээ больчихооч. Тэгээд энэ 2 яамнаас 2 асуулт.

Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр үнэн үнэн. Тэр магадлал яг хийгдэх үеэр бас энэ зарим нь бас гарч амжихгүй байж байгаад төсөв хэлэлцэж энэ жилийн төсөв боловсруулах ажил чинь хууль өөрчлөгдсөнөөс болоод бүтэн 1 сарын өмнөөс эхэлчихсэн нэг ийм тал бий. Бас Боловсролын яамны зүгээс бас энэ тал дээр өөрсдөө бас юмаа ойлгуулж чадаагүй тал байгааг таны шүүмжлэлийг бүрэн хүлээж авна.

Бусдаар гүйцэгдэх ажлын дотоод агуулга нь 22 тэрбум нь сурах бичиг, хөтөлбөр шинэчлэх, сурах бичиг хэвлүүлэх ийм ажилд 22, хөтөлбөрийн шинэчлэл дээр 11 тэрбум, цахим шилжилтийн арга хэмжээ дээр 20 тэрбум, 52 тэрбум нь нийтлэг үйлчилгээг хувийн хэвчлээр хийлгэх энэ ажил байгаа.

Өөрөөр хэлбэл, сургуулийн цэвэрлэгээ, янз бүрийн үйлчилгээнүүд, харуул хамгаалалт эд нар гэсэн зүйлүүдийг заавал ажилд авч, төрийн үйлчилгээний албанд авч ингэхгүйгээр хувийн хэвчлээр гүйцэтгүүлье гэсэн ийм байгаа. Тэр хувийн хэвшил рүү шилжүүлж тэр үйлчилгээг авахад хийж байгаа. Мөн дотуур байрны үйлчилгээ бол 20 тэрбумаар нэмэгдэж байгаа. Энэ хүүхдийн тооны өсөлттэй

холбоотойгоор ийм л зардлууд байгаа. Баярлалаа.

Г.Дамдинням: Хүүхдийн тооны өсөлт. Энэ тэгээд миний ойлгосноор бол энэ 92 тэрбумын чинь 52 тэрбум нь Наранбаяр сайдаа тэр сургууль, цэцэрлэгийг, сургууль, цэцэрлэг барих боломжгүй газруудад түрээслэх эрхийг Боловсролын ерөнхий хуулиар бий болгоод, тэгээд тэрийгээрээ энэ нөгөө сугалааны цэцэрлэг гэдэг юмыг байхгүй болгоод, хүртээмжийг нэмэгдүүлэх ажил хийсэн л гэж ойлгоод байгаа шүү дээ.

Санжаадорж ажлын хэсэг 6. Миний бодож байгаа л байх аа даа.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж, Байнгын хорооны даргын асуултад хариулъя. Ер нь бол бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж гэдэг эдийн засгийн ангилал байдаг. Энэ нь бол “Өү Си Ди”-гээр бол Гүүдс Энд Сервис гэдэг Сервис юм байгаад байгаа. Өөрөөр хэлбэл, төр бусдаар буюу хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх төр өөрөө заавал өөрөө бие дааж хэрэгжүүлэх шаардлагагүй ийм ажил, үйлчилгээ байгаа.

Манай төсөв бол 4 ангиллаар байгаа. Одоо ангиллаар бол ангилдаг. Төсвийн ерөнхий захирагчаар нь ангилж байгаа. Одоо хөтөлбөрөөр нь ангилж байгаа. Хөтөлбөр гэдэг нь жишээ нь, соёл, спорт, аялал жуулчлал байх юм бол соёл дээр тэд, спорт дээр тэд гэж ялгаж байгаа. Дээр нь зориулалт байгаад байгаа.

Тусгайлан асуусан яг хоёр яамны хувьд бол Боловсролын яамны хувьд дийлэнх нь буюу 52 тэрбум төгрөг нь бол одоо бид шинээр ашиглалтад орж байгаа энэ сургуулиуд дээр, мөн сургууль, цэцэрлэг, барих боломжгүй газрууд дээр бол байр ашиглалтын нийтлэг үйлчилгээ буюу цэвэрлэгээ үйлчилгээг заавал төрийн албан хаагч байгаад тангараг өргөж хийх шаардлагагүй. Энэ хүмүүсийг

хөлслөөд хувийн хэвшилээс сервис авъя гэдэг агуул.../минут дуусав./

Г.Дамдинням: Ойлголоо. Соёлын сайд Номин.

Ч.Номин: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Энэ манай дээр тавигдсан томилолт бол дандаа дотоод томилолтын нэгтгэлээр гарч ирж байгаа. Манай төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд бол нийтдээ 480 гаруй байгууллага байдаг. Энэ дотор байгууллагын өөрчлөлт орсон буюу нөгөө яамнууд нэгдэн нийлээд бид нар чинь өмнө нь Соёлын яам байж байгаад Соёл, биеийн тамир, аялал жуулчлал, залуучууд гээд тэгээд залуучуудын чиг үүрэг шинэчилсэн хуулиараа бас нэмэгдэж орж ирсэнтэй холбогдуулан өөрчлөлтүүд ороод тэгээд нэг байгууллага дээрээ хуваагаад үзэхээр дунджаар 2-5 сая төгрөгийн томилолтыг байгууллагууд маань өнөөдөр яг энд тавигдсан байгаа 50 гаруй байгууллагуудын томилолтын зардал буюу дотоод томилолт буюу биеийн тамир, спортын байгууллагууд, биеийн тамир, спортынхоо орон нутгийн байгууллагууд дээр ажиллах зардлууд гэх мэтчилэн ийм зүйлүүд дээр нэгтгэгдэж гарч ирсэн байгаа.

Би түрүүн Найдалаа гишүүний асуултад дутуу хариулж, гүйцээгээд хариулчих уу? Юу асуусан, тоног төхөөрөмж асуусан. Тэрийг би тайлбарыг нь хэлж өгч болох болов уу?

Г.Дамдинням: Гишүүний асуултыг тэр асууж байсан тэр үед нь л хариулчихна биз дээ. Таны минут дуусчихлаа.

Би нэмээд асууя. Нэг ийм юм байна. Мөн бас танай яамны төсөв дээр нэг ижил шахуу үүрэг, зорилготой 2 том төсөв яваад байгаа юм. Монгол Улсаа гадаад улсад сурталчлах гээд нэг төсөв байна лээ.

Нөгөөдөх нь аялал жуулчлалыг юуны билээ нэг тийм төсөв байгаад байгаа юм. Тэр 2 төсвийн заалтыг энэ манай энэ Төсвийн байнгын хорооныхон хэлэх байх. Яг ижилхэн 2 нэртэй, юу яг ижилхэн 2 зорилготой, 2 өөр нэртэй 20 орчим тэрбум төгрөгийн зардал яваад байгаа байхгүй юу. Энийг нэг тайлбарлаадхаач ямар учиртай юм?

Соёлын сайд Номин.

Ч.Номин: Би яг, ер нь яах вэ Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах ажил нь бол нэгдсэн журмаар Монгол Улсыг олон улсад сурталчлах буюу томоохон хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан монголын аялал жуулчлалын боломжуудыг нэмэх нь хөрөнгө оруулалтын боломжуудыг нэгтгэж сурталчлах ажлууд байдаг. Үүнд бол Си Эн Эн-ээр нэгдсэн сурталчилгаа хийлгэх байдаг юм уу, эс үгүй бол томоохон хэвлэл, мэдээллийн ВВС гэх мэтчилэн байгууллагуудаар хийгдэх байдаг. Энэний үр дүн нь маш сайн гарч явж байгаа.

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд бид бүхэн хувийн хэвшилтэйгээ хамтраад ямар нэгэн төсвийн санхүүжилтгүйгээр бид нар хийхэд нийтдээ Монгол Улсыг олон улсад эергээр танигдсан байдал 82 хувиар нэмэгдсэн буюу аялал жуулчлалын салбар өнөөдрийн байдлаар 706 мянган хүн хүлээж авсан, 1.4 тэрбум долларын экспортын орлогыг оруулж ирсэн байгаа.

Нөгөө зардлыг нь би зүгээр таны асууснаас ойлгоод хэлэхэд бол бид нар дээр бас ямар зардал байдаг вэ гэхээр монгол уран бүтээлчид олон улсын томоохон тавцан дээр өөрийн улсыг сурталчлан таниулах.../минут дуусав./

Г.Дамдинням: Номин сайд 1 минут гүйцээгээд хариулчих.

Ч.Номин: Морин хуурын чуулга, Үндэсний урлагийн их театр гэх мэтчилэн ийм томоохон урлагийн

байгууллагууд бол олон улсад томоохон тоглолт, уран бүтээлүүдийг хийдэг энэ болов уу гэж бодож байна.

Аялал жуулчлалын салбар дээр орж ирж байгаа зүйл бол ерөөсөө ямар нэгэн тийм сурталчилгаатай холбогдолтой зүйл орж ирээгүй байгаа.

Г.Дамдинням: Ойлголоо. Энэ зардлуудаа нэлээн сайн тэр зүйл, заалтыг нь энэ Сангийн яамтайгаа ярьж байгаад ойлгомжтойгоор энэ гишүүдэд танилцуулахгүй бол тэрийг чинь бас ойлгоход их төвөгтэй юм байна лээ шүү. Тийм.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дагуу зарчмын зөрүүтэй саналын томъёолол, одоо үг байхгүй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэсэн ийм дэгтэй байгаа.

Тэгэхээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.14 гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын 2-оос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна гэж заасны дагуу ирүүлсэн зарчмын

зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Тэгэхээр одоо хэдүүлээ энэ зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд үгээ хэлээд, зарчмын зөрүүтэй саналуудаа танилцуулаад ингээд явчихна.

Зарчмын зөрүүтэй саналуудыг танилцуулаад явъя. Зарчмын зөрүүтэй 8 байгаа билүү? 6 байгаа. 6 юу тээ? Зарчмын зөрүүтэй саналуудыг би энэчээнээс танилцуулаад явъя. Тэгээд зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд дэлгэрүүлж үг хэлэх бол хэлээд явна. Аль нь юм, энэ үү тээ?

1.Төслийн хавсралт 1.28.5.1-д “Хүн амд албан, албан боловсролд хамрагдаж, ажил амьдралын орчинд суралцах тэгш боломж бүрдүүлнэ” гэснийг “Хүн амд албан ба албан бус боловсролд хамрагдах, ажиллангаа суралцах боломжийг нэмэгдүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн.

Хэрлэн гишүүн үг хэлэх үү? Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ томъёоллын хувьд өөрчлөх зорилготойгоор энэ саналыг гаргасан байгаа. Хөтөлбөрийн зорилгоо томъёолохдоо бас нэг утга, найруулгын хувьд засаж сайжруулах хэрэг байна гэдэг утгаараа энэ саналыг гаргасан байгаа. Болсон тийм.

Г.Дамдинням: Санхүүжилт, үнийн дүнтэй холбоотой асуудал байхгүй. Яах вэ би сая бас энэ юуг чинь хараад сууж байхад юу л юм байна лээ Хэрлэн гишүүн ээ, Боловсролын ерөнхий хууль дээр бид нар өөрсдөө оруулчихсан саналын томъёолол нь яг хууль дээр байгаа хэллэгээрээ томъёологдоод явчихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг энийг нэг их өөрчлөөд, найруулаад явсны ач холбогдол гээд байх

ч юм бол байхгүй л байна л даа. Болчихсон доо, одоо дэгээр болчихсон. Одоо санал хураалт.

Хэдүүлээ дэгээрээ явчихъя. Та үгээ хэлсэн байна. Хэрлэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

46.2 хувиар санал уналаа. Дараачийн саналдаа оръё.

Төслийн 14.1.3.1 заалтын зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ гэсэн дээр Боловсролын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд 3 тэрбум бууруулах дүн, зардал нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэм хэмжээ гэсэн дээр Боловсролын салбарын тоног төхөөрөмж Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 3 тэрбум төгрөг гэж, Мөнхтуяа гишүүн санал гаргасан байна.

Мөнхтуяа гишүүн саналаа танилцуулж хэлэх үү? Мөнхтуяа гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхтуяа: 2023-24 оны хичээлийн жилд Нийслэлийн Баянзүрх дүүргийн хэмжээнд ерөнхий боловсролын 68 сургууль байгаагаас 33 нь төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, 186 нь цэцэрлэг байгаагаас төрийн өмчийн 59 нь цэцэрлэг ингээд Боловсролын яамнаас гаргасан статистикаас авсан мэдээлэл байгаа.

Энэ төсвийн хөрөнгө оруулалт дээр хамгийн бага компьютер, тоног төхөөрөмж авсан энэ газар Баянзүрх дүүргийн багш нараас маш их гомдол ирж байгаа.

Тийм учраас энэ Баянзүрхийн сургууль, цэцэрлэгүүд дээр тоног төхөөрөмжийн зардалд гээд 3 тэрбум төгрөгийг гээд оруулсан байгаа. Зарчмын зөрүүтэй санал.

Энэ дээр би өөрөө яг энэ сургуулиудаар нь яваад яг бодитой энэ

дутагдалтай байгаа юмнуудыг нь аваад өгөх ийм юу тавьсан юм. Тэгээд та хэд маань бас дэмжээд өгвөл их сайн байна. Баянзүрх дүүрэг өөрөө боловсролын салбарын багш, ажилчдын тоогоороо хамгийн өндөр., тэгээд хүүхдийн тоо нь бас их өндөр ийм дүүрэг байгаа шүү. Тэгээд Баянзүрхийн багш нараас ирсэн саналын дагуу энэ саналыг би бас оруулж ирж байгаа юм 3 тэрбум төгрөгийн.

Г.Дамдинням: Ойлголоо. Боловсролын салбарт 34 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийн зардал улсын хэмжээнд тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгээд энэнээс 3 тэрбум төгрөгийг нь аваад зөвхөн Баянзүрх дүүрэгт тавья л гээд байна л даа. Тэгэхээр бусад улс орны маань хэсэг, нэгж бүр дээр яах вэ гэдэг л асуудал яригдана шүү дээ. Тэгээд Боловсролын сайд энэ дээр тайлбар хийгээдхээч.

Боловсролын сайд Наранбаяр.

П.Наранбаяр: Би ч өөрөө энэ Баянзүрх дүүргээс сонгогдсон гишүүний хувьд бол баярлаж байгаа юм.

Гэхдээ сайдын хувьд бол энэ арай болохгүй. Энийгээ би тайлбарлая. Нэгдүгээрт энэ бүх том багцаараа яг энэ Дамдинням гишүүний хэлсэнчлэн яг улс орон даяараа батлагддаг ийм байгаа. Улсын төсөв хэлэлцэж байгаа энэ нөгөө орон нутаг юм уу, энэ Нийслэлийн төсөв хэлэлцэж байвал бас болно л доо.

Тэгэхээрээ нэг ийм тал байгаа шүү зөв ойлгоорой. Харин энэ 24 оны төсвийн тодотголоор бид оруулаад энэ 24 он дотроо бас багтаагаад Баянзүрх дүүрэг дээрээ 11 сард бол 450 багшид яг энэ зөөврийн компьютер хуваарилж байгаа. Авч амжаагүй тэд чинь хамгийн их олон багш байгаа. Багш болгонд нь хүрээгүй байсан.

Тийм учраас яг энэ 450 компьютерыг хуваарилж байгаа. Энэ нь болохоороо яг нөгөө тэр Гүүгл Кромбүүк

/Google Chromebook/эд нар биш яг өөрийн гэсэн хаард/hard/-тай ийм зүйл байгаа. Тийм, ингээд ойлгож хандахыг хүсэж байна.

Тэгээд би өөрөө санал өгөх эрхгүй учраас ингээд сууж байгаа шүү. Уучлаарай.

Г.Дамдинням: Тэгэхээр нэг дүүрэг нь, эсвэл 1 аймаг нь 10 хувийг нь аваад явчихаар бусад аймаг, орон нутгууд нь яах ч юм? Тэрийгээ бас гайхаад л байна. Тэгээд гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

7.7 хувийн саналаар санал уналаа. Дэмжигдсэнгүй.

Мөнхтуяа гишүүн маань ойлгоод бас гаргасан саналынхаа эсрэг санал өгсөнд баярлалаа. Дараачийнх нь яг ижилхэн.

Төслийн 14.1.3.1 Боловсролын салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд гэж зааснаас 1.5 тэрбумыг бууруулж, зардал нэмэгдүүлэх төсөл дээр Завхан аймгийн Улиастай сумын 3 дугаар цэцэрлэг, 200 хүүхдийн өргөтгөлийн барилга барих 1.5 тэрбум төгрөг гэж.

Энэ хэн бэ Түвшин гишүүн үү? Түвшин гишүүний санал орж ирсэн байна. Тэгээд ойлгомжтой, тэгээд нөгөө бид нарын улс даяар хийх гэж байгаа, яг ижилхэн л байлгүй дээ Наранбаяр сайдаа тээ? Санал хураалт.

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараачийн саналдаа оръё.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан зардал бууруулах төсөл, арга хэмжээний нэр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 оны

төсвийн зарцуулалт 13 дугаар хавсралтад заагдсан Боловсролын сайдын багцад санхүүжүүлэгдэхээр тусгагдсан Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн зэрэг 6 эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төсвийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн багцад шилжүүлэхтэй холбоотой Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан Монгол Улсын төсвөөс 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах зардлын хэмжээг Боловсролын сайдын урсгал зардлыг 16 тэрбум 492.5 сая төгрөгөөр бууруулах, зардал нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээн дээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлыг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн ийм саналын томъёололтой санал орж ирсэн байна.

Өөрөөр хэлбэл, төсөл захиран зарцуулах Боловсролын сайдын төсвөөс Шадар сайдын төсөв рүү л авна гэсэн байна. Саналаа тайлбарлах эрх манай Рэгдэл гишүүнд байгаа. Рэгдэл гишүүнд микрофон өгье.

Д.Рэгдэл: Тэгэхээр энэ сая нэр дурдагдсан 6 эрдэм шинжилгээний хүрээлэн холбогдох сургуулийнхаа удирдлагуудтай ойлголцоод, тэгээд сургуулийн удирдлага, хүрээлэнгийн удирдлага нь Наранбаяр сайдад асуудлаа танилцуулж ойлгуулаад, тэгээд үүний үндсэн дээр Наранбаяр сайд, Гантөмөр сайд нар бас ойлголцоод сая 6 хүрээлэнг Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжүүлнэ гэдэг асуудал дээр тохиролцоонд хүрчихсэн байгаа юм.

Тэгэхдээ зэрэг зүгээр одоо энэ төсвийг нь Төсвийн тухай хуульд нийцүүлээд Наранбаяр сайдаас явж

байгаа уг хүрээлэнгүүдийн төсвийг очиж байгаа Гантөмөр сайдын төсөв дээр л оруулчих тухай асуудал. Энэ угаасаа ингэж явахгүй бол, ингэж хуульдаа, Төсвийн тухай хуульдаа тусгаж өгөхгүй бол хүрээлэн Засгийн газрын шийдвэрээр шилжчихсэний дараа төсөв нь өөр газар байж байвал энэ цаашаа үйл ажиллагаа явах боломжгүй болчих гэж байгаа юм. Тэгэхээр энэ ер нь л дэмжихээс аргагүй л санал л даа.

Г.Дамдинням: Боловсролын сайд Наранбаяр тайлбар хэлээдхээч. Энэ нэг л сонин л юм байна даа. Дараа нь Сангийн сайд хэлнэ байх.

П.Наранбаяр: Энэ ойлгуулсан, ойлголцсон. Энийг юу гэж, та бүхэн хашилтад ойлгоорой.

Тэгэхээр 16 хүрээлэн байгаа. Энэнээс 6 хүрээлэн нь буюу энэ 16 хүрээлэнгийн яг энэ их, дээд сургуульд харьяатай 16 хүрээлэнг нийтдээ энэ 6 хүрээлэн нь ойролцоогоор 400, 500, 100-аас дээш ажилтантай ийм том хүрээлэнгүүд байгаа юм. Тэгээд Анагаах ухааны харьяа, их сургуулийн харьяанд байсан 2 хүрээлэн, Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяанд байгаа 4 хүрээлэн нийлээд үйлдвэрчний эвлэл нь бослого гаргаад, над руу хандаад, за тэгээд удирдлагууд нээрээ Шинжлэх ухаан технологийн сангийнхантай уулзаад тэндээсээ суурь судалгааны чинь зардлыг өгөхгүй шүү гэсэн юм сонсоод тэгээд тийшээгээ нийлье гэсэн л юм болсон.

Нэгэнт ингээд сургуулийн удирдлагатайгаа ярилцаад бид нүүлээ шүү, та бүхнээс туурга тусгас.../минут дуусав./

Г.Дамдинням: Сангийн сайд болох юм уу энэ төсөв, зарлагын хувьд? Ер нь бол байна шүү, ер нь бол байна шүү Төсөв хуультай шүү. Төсөв хуультай шүү. Жишээ нь, энэ 2 яамны хоорондын асуудал яригдаж байна. Тэгээд 2 яамны хоорондын асуудал яригдаж байхад

нөгөө яамнаас нь асуудал бид нарт орж ирэх ёстой. Тэгээд танилцуулга бол боллоо. Тэгэхээр би бол мэдэхгүй юм байна бас наадхыг чинь. Ийм юм болдог ч юм уу, үгүй ч юм уу. Уг нь бол засгийн тогтоол гараад, засгийн тогтоолын дараа төсвийн зардалд шилжих ёстой ийм л зарчимтай шүү дээ. Тэгэхээр би энэ дээр гараагүй юмыг чинь яаж шилжих юм. Санал хураалт.

7.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй. Дараачийн саналдаа орёе.

2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 4.2.1.1-д заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсөл, арга хэмжээ, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын төсвөөс санхүүжих дүн 30.4 тэрбум төгрөгийг гэснийг бууруулах, 10 тэрбум төгрөгөөр бууруулна. Зардал нэмэгдүүлэх төсөл дээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн хавсралт төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж жагсаалтын 4.2.2-т тоног төхөөрөмж, 4.2.2.1-д хэрэглээний био технологийн лабораторийн тоног төхөөрөмж гэж тусгасан, тусгасан дээр 10 тэрбум төгрөг нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл.

Рэгдэл гишүүн.

Д.Рэгдэл: Тэгэхээр энэ Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдын багцын дотор яригдаж байгаа асуудал, хөрөнгө оруулалтын хүрээн дээр яригдаж байгаа. Тэгэхээр энэ ямар үндэслэл тавиад байгаа юм гэх дээр зэрэг

манай улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд шинжлэх ухаан, технологийн салбарт ДНБ-ий 2 хүртэл хувийг өгнө гэсэн нэг ийм заалт яваад байгаа.

Хоёрдугаарт бол Монгол Улсын хөгжлийн 25 оны төлөвлөгөөнд шинжлэх ухаан, технологийн инновацад суурилсан мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлнэ гэсэн ийм тодорхой заалт тусгаад, Засгийн газрын Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны 24, 28 оны хөтөлбөрт шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлыг ДНБ-ий 1 хувьд хүргэж, шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ гэсэн ийм заалтууд орчихсон ингээд явж байгаа юм.

Тэгэхээр зэрэг энэ салбарын зардлыг ингэж өсгөж явж байж 4 жилдээ зорилтдоо хүрэхгүй юм бол хамгийн сүүлийн жилд нь 27, 8 онд нь өсгөх юм бол салбар нь зардлаа шингээж чадахаа байчих нэг ийм аюултай.

Тэгэхээр энэ зардлыг өсгөх тал дээр зөв, зүйтэй санал, санаачилга гаргаж явах шаардлага бол хэн бүхэнд байгаа. Зүгээр энэ удаа барилгын хөрөнгө оруулалтын зардлаас аваад лабораторийн тоног төхөөрөмж дээр тавьдгийн учир юу байна вэ гэх дээр зэрэг энэ био технологийн, хэрэглээний био технологийн лаборатори бол ер нь Монгол Улсын гадаадаас дандаа авдаг Пи Си Ар дээр түшиглэсэн оношилгооны бэлдмэлийг Монгол Улсдаа өнөөдөр дэлхийд мөрдөгдөж байгаа хамгийн өндөр технологиор хийх ажлыг хариуцахаар ингэж хийгдэж байгаа лаборатори.

Тэгэхээр энэ лабораторийн ажлыг ямар ч байсан энэ удаа хөрөнгө оруулалтын зардлыг нэг зүйлээс, ангиасаа нөгөө зүйл рүү нь шилжүүлэх замаар эхлүүлээд, ингээд дараа жилд нь үлдсэн нэг арваны, арав арваны, арван

долоо аравны дөрвөн тэрбум төгрөгийн зардлыг дараа 26 оноос санхүүжүүлээд ингээд тодорхой хэмжээний судалгаа, үйлдвэрлэлийг зэрэг явуулдаг лабораторитой болох л ийм чин хүсэл эрмэлзэлтэйгээр энэ саналыг оруулж ирж байгаа юм.

Г.Дамдинням: Рэгдэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт.

53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төсвийн байнгын хороонд уламжлах нь ээ.

Бум-Очир гишүүн протоколд дэмжсэнээр тэмдэглэе. Дараачийн санал.

Төслийн 14.1.1.137 зардал бууруулах төсөл, арга хэмжээ Цэцэрлэгийн барилга буулгаж шинээр барих 240 ор, Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, 74 дүгээр цэцэрлэг, бууруулах дүн 5 тэрбум 910 сая төгрөг, аравны дөрвөн сая төгрөг, зардал нэмэгдүүлэх төсөл Цэцэрлэгийн барилга худалдаж авах 150 ортой, Улаанбаатар, Баянгол дүүрэг, 26 дугаар хороо, 2 тэрбум 100 сая төгрөг, 2.Цэцэрлэгийн барилга худалдаж авах 200 ортой, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 15 дугаар хороо, 3 тэрбум 100.4 сая төгрөг. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Галбадрах.

Галбадрах гишүүн тайлбар хэлэх үү? Галбадрах гишүүнд микрофон өгье.

Ж.Галбадрах: Энэ ерөөсөө манай салбар дотроо 1 цэцэрлэгийг 2 цэцэрлэг болгож байгаа төсөл гэж ойлгоорой. Энэ төсвийг нь хасаж байгаа. Бууруулж байгаа цэцэрлэг бол 74 дүгээр цэцэрлэг 22 онд төсөвлөгдсөн, улсын төсөвт туссан, 23 онд бас туссан. Тэгэхдээ ерөөсөө ямар ч ажил хийгдээгүй.

Яагаад хийгдээгүй вэ гэвэл энэ цэцэрлэг нурааж буулгаад дараагийнх нь

барих ёстой юм байгаа юм. Тэгэхээр оршин суугчид иргэд энийг бас эсэргүүцдэг, тэгээд байж байгаа барилгыг цэцэрлэгээр нь явъя гэдэг асуудал тавьдаг юм байна лээ.

Гэвч нөгөө улсын Барилгын хөгжлийн төв энэ тэрээс юунууд орж ирээд энэ бол ингээд ашиглах боломжгүй, цэцэрлэгээр нь ашиглах боломжгүй ээ нурах, барих ийм магадлал үүссэн гэж ингээж хэлдэг юм байна лээ.

Тэгэхээр ерөөсөө энэ нураана гэдэг асуудал нь энэ том асуудал болоод энэ төсөв дээр тусгагдсан ч орж өгдөггүй юм байна. Ерөөсөө хэрэгждээгүй явсан байна.

Энэнтэй зэрэгцүүлээд Баянгол дүүрэг маш их хүнтэй, Хан-Уул дүүрэг 150 ортой цэцэрлэг, 200 ортой цэцэрлэгийг манай Боловсролын яам 2 жил гаран түрээсээр ингээд яваад байсан байна. Тэгээд нөгөө 2 цэцэрлэг маань одоо болохоор түрээсээр өгөхгүй ээ, зарвал зарна аа гэсэн ийм санал тавьчихсан юм байна.

Тэгээд тэр 150 ортой дээр нь явж байгаа хүүхэд нь 300 шүү. Бүүр 1 орон дээр 2 хүүхдээрээ байдаг. 200 ортой цэцэрлэгт нь бүүр 420 хүүхэд ингээж орох юм байгаа юм байна лээ.

Тэгэхээр энэ нэгэнт баригдахгүй байгаад байгаа энэ төслийг цааш нь энэ 2, бид нар түрээсээр хэрэглэж байсан энэ 2 цэцэрлэгээ худалдаж аваад маш их эрэлт, хэрэгцээтэй газар барих гэж байгаа юм байна. Тэгээд энэ утгаар нь та бүхнийг дэмжээд, энэ дотроо 1 цэцэрлэг маань 2 цэцэрлэг, тэгээд яг хэрэгцээгээ олсон ийм зүйл дээр очиж байгаа юм байна гэдгийг хэлье.

Г.Дамдинням: Яах вэ 2 л юм байна.

Нэгдүгээрт, бид нар бүгдээрээ л тойрог тойрог, тэгээд л өөр өөрийнхөө

салбарыг төлөөлөөд л явж байгаа Улсын Их Хурлын гишүүд. Би жишээ нь гэхэд Чингэлтэй дүүргээс сонгогдсон гишүүдийн байр суурийг бол сонсоогүй учраас энд нэг л жоохон эвгүй л байна. Яах вэ хэдийгээр бид нарт бүрэн эрх нь байгаа ч гэсэн. Хоёр талаасаа сонсох ёстой байхгүй юу. Төсөв гэдэг чинь анхнаасаа боогдохдоо тал талдаа яригдаад л явж байгаа.

Хоёрдугаарт, Ганбат дарга та хариулаадхаач. Төсөл дээр, төсөв дээр барилга байгууламж худалдаж авах тухай зардал байгаа юм уу? Байхгүй л санагдаад байх юм. Ажлын хэсгийн 7.

Ж.Ганбат: Энэ яг худалдаж авна гэх дээр бас, энэ яах вэ өмнө нь практик дээр, яах вэ төсөв дээр ийм асуудал бас аягүй тийм сөрөг үр дагаврууд агуулж байсан.

Жишээ нь, энэ дээр яг тэр тухайн юмыг бид байришаар нь худалдан авалтыг нь зохион байгуулна шүү дээ. Тэгэхээр энэ дээр бас нэлээн асуудлууд үүснэ, үнэлгээний асуудлууд гарч ирнэ. Тэгэхээр өмнө нь Боловсролын яам, энэ бусад яамнууд дээр явж байсан энэ асуудлууд дандаа асуудлууд дагуулж ирсэн ийм юмнууд л байгаа юм.

Г.Дамдинням: Ойлгомжтой. Санал хураалт.

46.2 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийнх нь Баярмаа гишүүн байна.

Төслийн 2.6.34 зардал бууруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын төсвийн багцын хүүхэд, залуучуудад соёлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрхийн бичиг төрөөс үнэгүй олгох, бууруулах дүн 18.3 тэрбум төгрөг.

Энийг зардал нэмэгдүүлэх зүйл, заалт заагаагүй байна. Төсвийн хэмнэлт болгох гэж орж ирж байгаа юм байна. Төсвийн алдагдлыг бууруулж байна гэж ойлгож байна тээ? Санал гаргасан гишүүн Баярмаа тайлбарлая. Баярмаа гишүүнд микрофон өгөөрэй. Баярмаа гишүүнд микрофон өгье.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Тийм ээ би одоо юм бууруулах гээд л аминдаа л жоохон төсөв хэмнэх гээд л яваад байгаа юм л даа. Тэгээд Байнгын хороодоор л орох юм. Тэгээд л унаад л байх шиг байна ерөнхийдөө.

Тэгэхээр энэ ийм учиртай юм байна лээ л дээ. Соёлын үйлчилгээ үзүүлэх зорилгоор эрхийн бичиг төрөөс үнэгүй олгоно гээд. Тэгээд би нэг жоохон асууж сурагласан чинь соёлын үйлчилгээ үзүүлнэ гэхээр яг ямар үйлчилгээ үзүүлэх юм? Тэгээд үнэгүй ингэж үзүүлнэ гэдэг ийм юм байж болдог юм болов уу гээд сураглахаар кино ч байж болно, ер нь жүжиг ч байж болох юм шиг ойлгосон.

Тэгэхээр энэ чинь төрөөс иргэдийг үнэгүй кино, жүжиг үзүүлж байгаа нь ямар зорилготой юм болоо гээд гайхаад байгаа юм. Түрүүн би энэ асуулт асуух байсан жоохон хоцроод ороод ирсэн учир асуулт асууж чадсангүй. Тэгэхээр энэ бол бас хууль талаасаа бол аудитын дүгнэлтэд ингэж байгаа юм. Энэ арга хэмжээгээ зохион байгуулах тэр журам, санхүүжилтийн хэмжээг нь Засгийн газраас тогтоож өгөх ёстой байсан боловч тогтоож өгөөгүй, журам нь гараагүй.

Тэгэхээр энийг журам нь гараагүй, хэмжээ нь тогтоогдоогүй, хэнд, хэдэн төгрөгийн ваучер үнэгүй олгох нь тогтоогдоогүй байхад энийг оруулж ирдэг нь хуулийн хувьд бол буруу гэж аудит дүгнэсэн байгаа юм.

Нийгэм, эдийн засгийн үр нөлөө гээд үзэх юм бол эдийн засгийн хувьд бол мэдээж ямар ч үр нөлөөгүй байх. Нийгмийн үр нөлөө гээд тэгэхээр иргэд маань үнэгүй жүжиг, кино л үзэх нэг ийм л нийгмийн ач холбогдолтой юм шиг байгаа юм.

Гэтэл нөгөө бид нарын чинь халамжаас хөдөлмөрт тээ, ер нь халамжийн чиглэлийн энэ үргүй зардлаа таная, хасья гэж байгаа нөгөө 30 жил зорьж яваа тэр үйл ажиллагаа, тэр бодлоготой чинь нийцэж байгаа юм болов уу? Энийг тараахгүй, өгөхгүй байснаар иргэд маань соёлгүй, боловсролгүй болох гээд байгаа юм болов уу гээд гайхаад л байна л даа. Тэгээд үнэгүй ийм билет авч үзээрэй гээд ваучер тараадаг ийм ер нь жишиг дэлхийд бас байдаг юм болов уу гэдгийг ерөөсөө ойлгохгүй байна.

Тийм учраас магадгүй энэ журам нь гараад тэр хэмжээ юм нь тогтоогдоод, энэ нь зөв, зүйтэй гэж үзэх юм бол магад дараа жилийн төсөвт дахиж орж ирж болох юм.

Түүнээс биш энэ жилдээ энийгээ танаач гээд. Сая энд зөндөө сургууль, цэцэрлэгийн асуудал ярьж байна. Яах вэ энэ яг Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо учраас би яг далимдуулаад хэлчихье Түвшин гишүүн байхгүй байна. Уг нь Түвшин гишүүн тэр зарчмын зөрүүтэй саналыг оруулж ирэх байсан. Би тэгээд Завхан аймагт намайг зориуд ирж үзээч ээ гээд бүүр урьсны дагуу би очсон байгаа. Тэнд бол 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгт 295 буюу 300 хүүхэд хүмүүжиж байна лээ.

Тэгээд 10 ширхэг гэр барьчихсан, 100 байр, 100-гийн байрандаа 150-ийг чихэж оруулаад, тэгээд гэр бариад 145 хүүхэд, 1 гэрт 28, 30 хүүхэд хичээллэж байгаа. Багш нар нь өөрснөө галаа түлдэг, модоо хөрөөддөг, түлээгээ хагалдаг. Бид нар гадаа гарч эр, гэрт орж эм болж байна, маш хүнд байна

гэж бүр хэлсэн. Гишүүнээ та энийг ирээд үзээч, хараач ээ, цаашаа танилцуулаач ээ. Зураг, төсөв нь бэлэн гэж байгаа юм. Тэгээд 24 оны төсөвт суулгаж чадаагүй, сая 25 онд бас суулгаж чадсангүй гээд.

Тэгээд энийг яах вэ Завханаас сонгогдсон гишүүн маань оруулаад би дэмжээд ярина гэж байсан боловч яг юу болсныг нь би сайн мэдэхгүй байна. Тэгэхээр ийм ийм тулгамдсан нөгөө хүүхдийн асуудал, нөгөө эрүүл мэнд, соёл, боловсролын асуудал байсаар атал заавал ч үгүй их үнэгүй ингэж ваучер авч жүжиг үзээд байх шаардлагагүй байх.

Тийм учраас аль болох хэмнэх, танах, хасах гэдэг юм руугаа орохгүй бол одоо ерөөсөө хэн дуртай нь нэг хууль боловсруулаад л, тэр хуульдаа нэг ийм ийм юм олгоно гэж бичээд л. Тэгээд хууль хэрэгжүүлэх гэж байна гээд л ингээд л төсөвт ийм маш их дарамт, ачаалал өгдөг энэ жишигийг бид нар энэ шинэ парламент халах ёстой. Ерөөсөө хуульчлагдсан ийм халамжийн бодлого явж байна. Тэгээд л яагаад гэхээр хуульд тусгагдсан, одоо өгөхөөс.../минут дуусав./

Г.Дамдинням: Энэ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хууль дээр л явж байсан юм байна даа. Соёлын сайд Номин тайлбар хэлээдхээч.

Ч.Номин: Баярмаа гишүүний асуултад хариулаад, тайлбар хэлье.

Гишүүн бас төсөв хэмнэх гэж байгаа гэдэг бол зөв байх. Энэ бол аягүй зөв. Гэхдээ бид бас үр хойч болсон өсвөр насныхнаасаа энийг хэмнээд нэг их бас давуу тал үүсэхгүй болов уу гэж би бодож байна.

Би таныг ойлголт дутуугаасаа ийм үйлдэл гарч байгаа болов уу гэж бодож байна. Тийм учраас би танд бүрэн хэмжээнд энэний танилцуулгыг хийхэд бэлэн байна. Өнөөдөр би тодорхой

түвшинд танилцуулга өгье гэж бодож байна.

Ер нь хүнийг хүн болгодог зүйл бол соёл байдаг. Нөгөө талдаа боловсролыг зөвхөн ганцхан сургууль гэхгүй, сургуулиас гадуур орчинд авах боломж байдаг.

ЮНЕСКО-гийн сурах зарчим гэж байдаг. Энэ зарчмын хүрээнд бол боловсрол орлох орчнууд бол сургуулийн орчноос гадна бусад соёлын орчнууд байдаг. Та ганцхан кино, жүжгээр хязгаарлаж байна. Энэхүү эрхийн бичгийг авсан хүүхдүүд ном товхимол худалдаж авах, дугуйлан секцэд хамрагдах боломж жуудыг бий болгож байгаа ийм эрхийн бичиг байгаа.

Би танд хуулийн эрх зүйн үндэслэлүүдийг нь ганцхан соёлын бүтээлч үйлдвэр гэхгүй хэлж өгье. Үндэс.../минут дуусав./

Г.Дамдинням: Номин сайд 1 минут.

Ч.Номин: Ер нь Үндсэн хуульдаа бол эрх, тэгш соёлыг хүртэх эрхтэй гэж байгаа. Хүүхдийн тухай хуульд мөн ялгаагүй энэ орсон байгаа. Соёлын бүтээлч үйлдвэрийн тухай хууль дээр бас орсон. Энийг хэрэгжүүлэхийн тулд Соёлын яамнаас 4 жилийн хугацаанд судалгаа хийгээд, 50 мянган хүүхэд дээр тандалт судалгаа хийгээд 94 хувь нь бидэнд энэ соёлын эрхийн бичиг хэрэгцээтэй байна гэдэг нь 2023 оны 11 сард батлагдаж гарч ирсэн. Олон улсад 100 гаруй газар энэ соёлын эрхийн бичиг хөгжингүй болон хөгжсөн орнуудад байдаг. Та судлаад үзвэл калчерал ваучер/cultural voucher/ юм уу, пасс култур/pass culture/ гээд гараад ирнэ.

Тэгэхээр бид нар энэ соёлыг түгээх хүрээндээ энэ судалгааны үр дүн дээр хүүхэд залуучуудын тандан судалгаан дээр суурилж гаргах гэж ирсэн. Энэ бол халамж биш, энэ бол

хүүхдэдээ оруулж байгаа хөрөнгө оруулалт, өсвөр насны хүүхдүүдэд зориулсан. Энэхүү эрхийн бичгээр хүн өөрөө өөрийгөө хөгжүүлэх, хүний хөгжлийн асуудлууд дээр хандаж орж ирж байгаа зүйлүүд байгаа.

ЮНЕСКО-гийн хамгийн сүүлийн судалгаагаар Монгол Улс хүний хөгжлийнхөө асуудлуудыг хойно орхигдуулснаас болж өнөөдрийн энэ ёс зүйн болон бусад энэ.../минут дуусав./

Г.Дамдинням: Тэгэхээр энэ дээр юу байгаа юм? Дэгийн хуулиараа хурал даргалагч л юм хэлэх байх даа. Тэгээд өөр ч хэлэх юм бол алга.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулийг бол би өөрөө бас нэлээн түлхэж Байнгын хороон дарга байхдаа батлуулж байсан хууль. Нэг.

Хоёрдугаарт, Боловсролын багц хуулийг бас ахлаад батлуулж байсан хуулиуд байгаа. Энэ хуулиудыг хэлэлцүүлээд явж байхад хамгийн том яригдаж байсан асуудал бол боловсрол болоод байна. Хүүхдүүд, өсвөр насныханд боловсрол болоод байна. Хүнээр хүн хийх, хүмүүжил боловсрол, төлөвшилтэй холбоотой асуудлыг бид нар орхигдуулаад байна гэдэг ийм л асуудал яригдсан.

Тийм ч учраас зарим Улсын Их Хурлын гишүүд Хүмүүнлэг боловсролын тухай хууль гэх мэт хуулиудыг санаачлаад оруулж ирээд Улсын Их Хурал дээр хэлэлцүүлээд явж байсан байхгүй юу өмнөх парламентад.

Тэгэхээр бид нар энэ дээр зүгээр Баярмаа гишүүн бол бас нэлээн чухал саналууд хэлээд байгаа юм сонсогдоод харсан. Тэгээд сая хэллээ. Гол асуудал нь юу байгаа вэ гэхээр Засгийн газар журмаа батлаад, хэмжээ хязгаараа тогтоогоод юу юун дээр байх ёстой вэ гэдгээ бас нэг тодорхой болгож Их Хурал

дээр танилцуулж байж яваач л гэдэг асуудал яриад байгаа юм байна л даа.

Гишүүд, ажлын хэсгийнхэнд талархал илэрхийлье.

Тэгэхээр энийгээ хэдүүлээ нэг хийе. Тэгэхдээ бид Боловсрол, соёл, спортын байнгын хорооныхоо хувьд хүүхэд, залуучуудтай хамгийн ойрхон ажилладаг Байнгын хорооныхоо хувьд энэ хүмүүжилтэй холбоотой асуудлыг нь бол унагаад яах вэ гэсэн ийм л миний хувийн бодол байна. Зүгээр ний нуугүй хэлэхэд энэ Төсвийн байнгын хороон дээр очиж шийдэгдэнэ. Төсвийн байнгын хороон дээр хэдээр шийдэгдэх тухай асуудал вэ гэдгийг тэр үедээ тэр Байнгын хорооны ажлын хэсэг, төсвийн ажлын хэсэг дээр манай гишүүд бас ярилцаад явна биз. Өнөөдрийн тухайд хэдүүлээ саналаа хураагаад явуулчихсан нь зөв байх гэж бодож байна. Санал хураалт.

16.25 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

30.8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Санал хураалтыг явуулж дууслаа.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал өндөрлөсөн тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.